

ЗАСГИЙН ГАЗРЫН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**УЛААНБААТАР ХОТ
2021 ОН**

АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн:

Аудитын хоёрдугаар газрын
захирал, тэргүүлэх аудитор:
Ц.НаранчимэгАудитын дөрөвдүгээр газрын
захирал, тэргүүлэх аудитор:
Я.СамбуунямАудитын менежер:
Г.Гүнжидмаа

Ц.Хосжаргал

Ахлах аудитор:
Д.Цэрэндорж

Р.Цолмон

А.Даваадорж

Б.Энхжин

Аудитор:
Ц.Цэрэнхүү

С.Бат-Эрдэнэ

Г.Мөнхчимэг

П.Амарсанаа

Э.Бүгүнүтэй

Г.Түвшинзаяа

Ж.Нямцэцэг

Н.Баттөгөлдөр

2021 оны 6 дугаар сар

Уг тайланг УАГ-ын
Цахим хуудаснаас үзнэ үү:
www.audit.mnАудитын тайлантай
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах
зүйл байвал 261663 дугаар
утсаар харилцана уу.ХАЯГ:
Үндэсний аудитын газар
Засгийн газрын IV байр,
Бага тойруу-6,
Улаанбаатар-46
Монгол Улс

АГУУЛГА	1
АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ	5
АУДИТ ХИЙСЭН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН	7
АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН БАЙДЛЫН ТАЙЛАН	7
АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН	8
АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	9
АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	10
АУДИТЫН ТАЛААРХ ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	12
АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ	12
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ	12
АУДИТЫН АРГА ЗҮЙ	12
МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН ТҮВШИН	12
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ХҮРЭЭ БА САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН АРГАЧЛАЛ, ЗАРЧИМ	12
ТАЙЛАНГ ИЛЭРХИЙЛСЭН МӨНГӨН НЭГЖ	13
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН	13
АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР	14
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН БАЙДЛЫН ТАЙЛАН	14
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН	14
НЭГТГЭСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	14
НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	14
НЭГ. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	15
ТӨВ ТӨРИЙН САНГИЙН МӨНГӨН ХӨРӨНГӨ	16
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН МӨНГӨН ХӨРӨНГӨ	16
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН МӨНГӨН ХӨРӨНГӨ	17
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН МӨНГӨН ХӨРӨНГӨ	18
ХОЁР. БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	19
ГУРАВ. АВЛАГА	20
ТӨВ ТӨРИЙН САНГИЙН АВЛАГА	21
ГАДААД ЗЭЭЛЭЭС ДАМЖУУЛАН ЗЭЭЛДҮҮЛСЭН ЗЭЭЛИЙН АВЛАГА	21
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН АВЛАГА	22
ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН АВЛАГА	22
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН АВЛАГА	23
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН АВЛАГА	23
ДӨРӨВ. УРЬДЧИЛГАА	24
ТАВ. БАРАА МАТЕРИАЛ	24
ЗУРГАА. БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	25
ДОЛОО. УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	25

НАЙМ. ҮНДСЭН ХӨРӨНГӨ	26
ДУУСААГҮЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ	26
ЕС. ӨР ТӨЛБӨР	27
ҮНЭТ ЦААС, ЗЭЭЛИЙН ӨГЛӨГ	28
ТӨВ ТӨРИЙН САНГИЙН ҮНЭТ ЦААС, ЗЭЭЛ	28
ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭД	29
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ӨР ТӨЛБӨР	30
НИЙГМИЙН ДААТГАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ӨР ТӨЛБӨР	30
АРАВ. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО	30
АРВАН НЭГ. АСУУДЛЫГ ОНЦЛОХ ХЭСЭГ БА БУСАД АСУУДЛЫН ХЭСЭГ	31
АРВАН ХОЁР. АУДИТЫН ГОЛ АСУУДАЛ	32
АРВАН ГУРАВ. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ДҮН	32
УЛСЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ	32
ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ	33
ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ	33
ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ	34
АРВАН ДӨРӨВ. САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ, ЗАЛРУУЛГА	34
АРВАН ТАВ. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ	35
АРВАН ЗУРГАА. ДОТООД АУДИТ	35
АРВАН ДОЛОО. ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ	35
АРВАН НАЙМ. ДҮГНЭЛТ	36
АРВАН ЕС. АУДИТЫН ЗӨВЛӨМЖ	36
УЛСЫН ИХ ХУРАЛД ТОЛИЛУУЛАХ НЬ:	36
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД-Д:	36
САНГИЙН САЙД-Д:	37

Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АЗЗА	Авто зам, засвар арчлалт
АОУС	Аудитын олон улсын стандарт
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БХЯ	Батлан хамгаалах яам
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ГХЯ	Гадаад харилцааны яам
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЖДҮХС	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
ЦТС	Цахилгаан түгээх сүлжээ
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗГСНТ	Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
ЗГ	Засгийн газар
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
МИАТ	Монголын иргэний агаарын тээвэр
МУЕС	Монгол Улсын Ерөнхий сайд
МУШС	Монгол Улсын Шадар сайд
МУДШ	Монгол Улсын Дээд шүүх
НДҮЗ	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДС	Нийгмийн даатгалын сан
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОББҮХ	Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНТЕЗ	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч
ОУВС	Олон улсын валютын сан
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨААТҮГ	Төрийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
УТЕЗ	Улсын төсвийн ерөнхийлөн захирагч
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ЭХЯ	Эрчим хүчний яам
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2-т заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүдийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшингээс давсан нь “Хязгаарлалттай” дүгнэлт өгөх үндэслэл болсон. Үүнд:

1. “Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай” хууль, дагалдах журамд сангийн эх үүсвэрийг нөхөн бүрдүүлэх талаар тодорхой тусгаагүй, чөлөөлөлтөөс үүссэн 642.6 тэрбум төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
2. Дамжуулан зээлийн 321.7 тэрбум төгрөгийг ашиглагч байгууллагууд санхүүгийн тайланд өр төлбөрөөр бүртгэж тайлагнаагүй;
3. Төрийн өмчит хуулийн этгээдийн ирээдүйд бий болох орлогоос төрд ногдох өгөөжийг барьцаалан 1,146.7 тэрбум төгрөгийн урт хугацаат үнэт цаас гарган, өр үүсгэж, иргэдийн тэтгэвэр барьцаалсан зээлийг төрөөс төлсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.7-д “төрөөс хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, хөтөлбөр, арга хэмжээ, татвар ногдуулалт, эсхүл хөнгөлөлт, баталгаа, зээл, өр төлбөр, санхүүгийн үйл ажиллагаа, болзошгүй өр төлбөр, тэдгээрийн үр дүн нь өнөө болон ирээдүй үеийн хооронд тэгш бус байдал үүсгэхгүй байх” гэж заасантай тус тус нийцээгүй;
4. Эдийн засаг, нийгмийн ач холбогдлоор нь эрэмбэлээгүй, эрсдэлийн үнэлгээ хийгээгүй 297.8 тэрбум төгрөгийн 12 төслийг гадаад зээлийн эх үүсвэрээс санхүүжүүлж, урт хугацаат өр төлбөрийг нэмэгдүүлсэн зэрэг нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Сангийн яам Монгол Улсын Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1-д заасны дагуу Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ

АУДИТ ХИЙСЭН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН**АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	21,006,560,185.1	22,690,732,864.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,148,944,340.3	4,859,650,012.7
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	763,276,202.2	896,714,916.4
33	АВЛАГА	5,569,329,211.2	5,486,456,120.2
34	УРЬДЧИЛГАА	1,186,439,445.6	2,295,599,586.9
35	БАРАА МАТЕРИАЛ	2,039,502,256.6	2,735,207,871.9
36	НӨӨЦИЙН БАРАА	189,215,746.7	162,832,743.8
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	5,109,852,982.5	6,254,271,612.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	46,193,912,649.4	55,861,299,159.8
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	8,540,913,055.8	10,040,403,204.4
37100	Урт хугацаат хадгаламж	67,467,173.6	490,969,261.4
37200	Үнэт цаас	1,693,048,171.4	2,329,124,279.0
37300	Урт хугацаат зээл	6,780,397,710.8	7,220,309,664.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	37,652,999,593.6	45,820,895,955.4
39100	Газар	33,357,051.2	277,258,522.0
39200	Биет хөрөнгө	20,971,129,203.1	22,889,985,235.8
39300	Биет бус хөрөнгө	15,388,675,631.4	17,959,651,023.7
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	1,259,837,707.9	4,694,001,174.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	67,200,472,834.5	78,552,032,024.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	33,178,696,000.8	42,659,815,495.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,521,882,442.4	5,203,111,460.0
41100	Богино хугацаат үнэт цаас	15,575,304.0	228,045,079.8
41200	Богино хугацаат зээлийн өглөг	1,441,547,672.1	1,605,983,263.6
41300	Өглөг	1,591,091,043.7	2,280,976,571.4
41400	Урьдчилж орсон орлого	473,668,422.6	1,088,106,545.3
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	29,656,813,558.5	37,456,704,035.7
42100	Урт хугацаат үнэт цаас	12,695,201,013.3	14,634,581,288.7
42200	Урт хугацаат зээл	16,961,612,545.2	22,822,122,747.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	34,021,776,833.7	35,892,216,528.6
51	Засгийн газрын хувь оролцоо	34,017,100,677.6	35,887,540,372.5
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	7,645,981,096.9	8,407,367,350.0
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	3,351,062,633.5	3,528,115,487.0
51102	Өмч /хувийн/ /ТӨҮГ/	22,994,670.3	16,828.6
51103	Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	11,285,344,372.1	11,712,874,184.8
51104	Халаасны хувьцаа /ТӨҮГ/	0.0	0.0
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	43,222,799.8	7,411,995.5
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	5,214,618,821.9	7,823,617,390.7
51200	Хуримтлагдсан үр дүн	-664,582,001.3	-3,976,076,742.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,111,898,622.6	7,881,593,472.9
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-13,091,784.2	-12,453,276.5
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	651,445.9	486,416,551.2
51600	Нөөцийн сан	19,000,000.0	28,657,130.6
52	Хяналтын бус хувь оролцоо	4,676,156.1	4,676,156.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	67,200,472,834.5	78,552,032,024.3

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	20,563,906,478.0	19,300,222,111.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	10,959,177,098.7	10,222,077,307.7
110	Орлогын албан татвар	2,968,371,433.0	2,231,573,392.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	933,148,175.5	864,737,694.4
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-37,932,127.1	-35,616,028.4
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	263,878.9	79,857.7
1103	ААН-ын орлогын албан татвар	1,701,002,737.9	1,402,371,868.4
1104	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	371,888,767.8	0.0
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	2,225,796,363.6	2,487,309,356.5
113	Хөрөнгийн албан татвар	154,369,122.2	154,878,633.1
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,486,268,106.2	2,208,953,720.4
115	Онцгой албан татвар	863,406,516.7	776,886,254.3
116	Тусгай зориулалтын орлого	16,355,040.0	17,071,698.5
117	Гадаад үйл ажиллагааны орлого	790,178,368.7	740,742,385.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,454,432,148.3	1,604,661,867.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,163,883,989.7	8,774,878,987.6
120	Нийтлэг татварын бус орлого	8,977,157,071.4	8,392,878,937.0
121	Хөрөнгийн орлого	2,318,553.7	22,316,976.6
122	Тусламжийн орлого	181,145,607.2	359,608,399.2
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	44,117.6	74,674.9
124	Зээлийн орлого	3,218,639.8	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	440,845,389.6	303,265,816.6
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	13,926,514,817.0	17,096,489,121.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,843,742,907.2	16,984,461,858.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,029,492,467.3	10,095,696,709.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,562,706,853.5	3,003,699,028.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	272,343,520.1	325,451,292.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	291,144,426.0	315,492,228.5
2104	Хангамж, бараа материалын зардал	430,496,156.6	391,393,729.2
2105	Нормативт зардал	363,087,428.9	424,725,868.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	81,926,006.1	98,404,204.1
2107	Томилолт, зочны зардал	86,800,768.4	66,624,034.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,000,879,052.2	3,222,925,481.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,940,108,255.5	2,246,980,842.4
211	ХҮҮ	1,439,469,161.5	1,653,585,986.3
212	ТАТААС	278,652,752.8	308,253,661.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,096,128,525.6	4,926,925,500.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	82,771,909.8	112,027,263.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	6,637,391,660.9	2,203,732,990.1
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	2,592,436,359.1	3,151,280,540.6
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,007,961,545.3	6,684,236,702.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	4,221,866,474.8	-1,329,223,171.5

АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	26,972,387,298.4	0.0	26,972,387,298.4
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	654,267,982.3	0.0	654,267,982.3
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	27,626,655,280.7	0.0	27,626,655,280.7
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	169,475,985.4	0.0	169,475,985.4
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,190,791,908.6	0.0	1,190,791,908.6
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	15,151,010.8	0.0	15,151,010.8
7	Өмчид гарсан өөрчлөлт	1,046,941,337.5	0.0	1,046,941,337.5
8	Зарласан ногдол ашиг	-249,105,164.2	0.0	-249,105,164.2
9	Тайлант үеийн үр дүн	4,221,866,474.8	0.0	4,221,866,474.8
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	34,021,776,833.7	0.0	34,021,776,833.7
11	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	34,021,776,833.7	0.0	34,021,776,833.7
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-40,283,563.4	0.0	-40,283,563.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	33,981,493,270.3	0.0	33,981,493,270.3
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	817,515,343.2	0.0	817,515,343.2
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-108,607,043.6	0.0	-108,607,043.6
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	7,265,610.9	0.0	7,265,610.9
17	Өмчид гарсан өөрчлөлт	3,867,413,792.6	0.0	3,867,413,792.6
18	Зарласан ногдол ашиг	-1,287,030,596.4	0.0	-1,287,030,596.4
19	Тайлант үеийн үр дүн	-1,329,223,171.5	0.0	-1,329,223,171.5
20	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	35,892,216,528.6	0.0	35,892,216,528.6

АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

		/мянган төгрөгөөр/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	24,796,180,798.5	24,765,288,606.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	10,955,778,262.3	9,914,142,480.5
110	Орлогын албан татвар	2,925,928,949.7	2,500,114,846.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	932,849,981.0	864,360,148.0
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-37,932,127.1	-35,616,028.4
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	263,878.9	79,857.7
1103	ААН-ын орлогын албан татвар	1,699,775,630.0	1,671,290,868.9
1104	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	330,971,586.9	0.0
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	2,179,594,832.9	1,785,430,003.9
113	Хөрөнгийн албан татвар	154,369,122.2	154,878,633.1
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,486,104,002.3	2,210,894,395.0
115	Онцгой албан татвар	863,401,414.0	776,900,367.6
116	Тусгай зориулалтын орлого	16,355,040.0	16,371,698.5
117	Гадаад үйл ажиллагааны орлого	790,179,283.2	738,837,953.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,539,845,618.0	1,730,714,582.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,362,179,166.1	1,542,899,180.0
1181	Газрын төлбөр	110,100,350.0	118,277,141.7
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	58,975,575.3	64,272,180.6
1183	Бусад татвар	8,590,526.6	5,266,080.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,373,191,602.7	14,365,363,119.4
120	Нийтлэг татварын бус орлого	13,306,476,786.4	14,235,321,162.8
121	Хөрөнгийн орлого	1,733,479.8	22,330,276.6
122	Тусламжийн орлого	64,793,308.0	107,446,721.7
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	188,028.4	264,958.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	467,210,933.5	485,783,006.9
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	19,075,472,065.4	21,124,704,953.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	19,075,472,065.5	21,124,704,953.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,778,098,638.8	13,737,460,709.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,356,462,191.6	3,882,349,904.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	495,295,078.4	548,774,964.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	591,257,245.4	625,349,388.7
2104	Хангамж, бараа материалын зардал	2,804,428,864.7	2,366,933,259.6
2105	Нормативт зардал	317,316,446.7	378,023,348.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	107,075,385.9	124,041,708.4
2107	Томилолт, зочны зардал	86,669,460.0	81,029,281.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,472,051,028.2	4,744,711,712.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,547,542,937.9	986,247,141.0
211	ХҮҮ	1,292,075,438.2	1,344,996,216.2
212	ТАТААС	293,298,104.2	323,594,755.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,711,999,884.3	5,718,653,273.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	5,720,708,733.1	3,640,583,653.1
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	369,559,826.2	213,437,309.1

V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	4,669,892,436.4	4,418,717,456.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,669,892,436.4	4,418,717,456.5
2200	Дотоод эх үүсвэрээр	4,669,892,436.4	4,418,717,456.5
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-4,300,332,610.2	-4,205,280,147.4
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	102,883,944.1	-724,597,833.4
14	Бусад эх үүсвэр	2,171,342,295.1	1,272,004,504.6
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	403,621,615.0	146,787,817.1
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	643,760,965.8	960,317,266.3
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	1,021,075,770.2	889,497,254.6
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,523,260,066.9	-1,289,294,327.7
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,625,684,273.4	6,148,944,340.3
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,148,944,340.3	4,859,650,012.7

АУДИТЫН ТАЛААРХ ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Аудит хийсэн үндэслэл

Үндэсний аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2-т заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Аудитын зорилт, хамарсан хүрээ

Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, УСНББОУС, СТОУС-ын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгуудыг Аудитын олон улсын стандартын дагуу сорьж шалгах нь аудитын горим юм.

Төрийн аудитын байгууллага нь Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, дүгнэлт гаргахын өмнө Төрийн аудитын тухай болон Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн захирагчид, төсөл, хөтөлбөр, сан, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн 2020 оны санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

Аудитын арга зүй

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдийг үндсэн шалгуур болгон хяналтын сорил, шинжилгээний горим гүйцэтгэж, түүврээр ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж, үнэлгээ өгөв.

Материаллаг байдлын түвшин

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн байгууллага, төрийн сан, төсөл, хөтөлбөр, сан, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайлангууд нэгтгэгддэг тул материаллаг байдлын түвшинг төлөвлөлтийн үе шатанд Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт үйл ажиллагааны зардал 13,926.5 тэрбум төгрөгийн 2.0 хувь буюу 278.5 тэрбум төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 23,780.7 тэрбум төгрөгийн 2.0 хувь буюу 475.6 тэрбум төгрөгөөр өөрчилж тогтоолоо.

САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ХҮРЭЭ БА САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН АРГАЧЛАЛ, ЗАРЧИМ

Сангийн яам Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 дэх заалтын дагуу Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн, хуулийн хугацаанд Үндэсний аудитын газарт ирүүлсэн.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу дараах байдлаар бэлтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн ерөнхийлөн захирагч хоорондын тооцоогоор баталгаажуулсан өр төлбөр, авлага, ажил гүйлгээний давхардсан 7,144.9 тэрбум төгрөгийг

санхүүгийн байдлын тайланд, 22,699.4 тэрбум төгрөгийг санхүүгийн үр дүнгийн тайланд, 25,410.6 тэрбум төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд тус тус устгал хийсэн;

- Төсвийн байгууллага, төсөл сан, төрийн сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд гэсэн төрлөөр ангилан тайлагнасан байна.

Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 56 ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэдгээрийн харьяа 4,627 төсөвт байгууллага, 561 төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээд, 370 төрийн сан, 1,332 төсөл сан нийт 6,890 санхүүгийн тайланг нэгтгэсэн байна.

Санхүүгийн тайланг бэлтгэсэн суурь

Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг УСНББОУС, СТОУС-ын дагуу нягтлан бодох бүртгэлийн тохируулсан аккрузл сууриар бэлтгэсэн байна.

Тайланг илэрхийлсэн мөнгөн нэгж

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалтын дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр, санхүүгийн нэгтгэсэн тайлан болон тодруулга тайланг мянган төгрөгөөр илэрхийлжээ.

Санхүүгийн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн

Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн яамны “Э-тайлан” программаар нэгтгэн гаргасан байна.

Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

А. Үндсэн тайлан	Б. Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан	В. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар, тодруулга
Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	НББ-ийн бодлого, зарчим 3-21 дүгээр тодруулгууд
Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	1а, 1б, 2а, 2б тодруулга
Засгийн газрын нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	Байгууллагын төрлөөрх нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	
Засгийн газрын нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	Байгууллагын төрлөөрх нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР**Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт**Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт хөрөнгө болон өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн 78,552.0 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 16.9 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт №1. Нийт хөрөнгө ба нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч			/сая төгрөг/	
Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Дүнд эзлэх хувь	
			Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Эргэлтийн хөрөнгийн дүн	21,006,560.2	22,690,732.9	31.3	28.9
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	46,193,912.6	55,861,299.1	68.7	71.1
Нийт хөрөнгийн дүн	67,200,472.8	78,552,032.0	100.0	100.0
Нийт өр төлбөр	33,178,696.0	42,659,815.5	49.4	54.3
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	34,021,776.8	35,892,216.5	50.6	45.7
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	67,200,472.8	78,552,032.0	100.0	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт хөрөнгө өмнөх оноос 11,351.6 тэрбум төгрөгөөр өсөхөд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ 3,313.7 тэрбум, Эрдэнэс Силвер Ресурс ХХК 1,043.7 тэрбум, Эрдэнэс Монгол ХХК 969.5 тэрбум, Тавантолгой төмөр зам ХХК 941.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны нийт үр дүн 1,329.2 тэрбум төгрөгийн алдагдалтай байгаа нь тайлант оны зардал орлогоосоо давсантай холбоотой байна.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нийт 243.4 тэрбум төгрөгийн ашигтай, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүн 2,236.0 тэрбум, төсөл сангийн үйл ажиллагааны үр дүн 1,162.4 тэрбум төгрөгийн тус тус эерэг /орлого нь зардлаасаа их/ үзүүлэлттэй, төрийн сангийн үйл ажиллагааны нийт үр дүн 4,970.8 тэрбум төгрөгийн сөрөг /зардал нь орлогоосоо их/ үзүүлэлттэй гарсан байна.

Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Засгийн газрын 2020 оны нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлангаар засгийн газрын хувь оролцоо 1,870.4 тэрбум төгрөгөөр өссөн нь харьяа байгууллагуудын тайлант үеийн үр дүн нэмэгдсэн, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын өмч 3,239.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Засгийн газрын 2020 оны мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлангаар мөнгөн орлого 26,250.7 тэрбум, зарлага 27,540.0 тэрбум, цэвэр мөнгөн гүйлгээ -1,289.3 тэрбум төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА, АУДИТЫН ДҮН

Нэг. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 6,148.9 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,859.6 тэрбум төгрөг болж, 1,289.3 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2. Мөнгөн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	59,787.4	56,028.3	-3,759.1	1.1
Банканд байгаа бэлэн мөнгө	4,815,508.5	4,231,333.7	- 584,174.8	87.1
Замд яваа мөнгөн хөрөнгө	67,400.0	59,268.2	-8,131.8	1.2
Хадгаламж	1,206,248.4	513,019.8	-693,228.6	10.6
Дүн	6,148,944.3	4,859,650.0	-1,289,294.3	100.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>				
Төсөвт байгууллага	323,762.1	188,215.5	-135,546.6	3.9
Төсөл/ сан	2,097,164.7	2,161,998.8	64,834.1	44.5
Төрийн сан	1,098,823.1	524,545.5	-574,277.6	10.8
ТӨҮГ болон ОНӨҮГ	2,629,194.4	1,984,890.2	-644,304.2	40.8
Дүн	6,148,944.3	4,859,650.0	-1,289,294.3	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө өмнөх оноос буурахад төсвийн орлого төлөвлөснөөс 420.8 тэрбум төгрөгөөр тасарсан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн сангийн мөнгөн хөрөнгийн бууралт голлон нөлөөлсөн байна.

Банканд байршиж буй харилцах болон хадгаламжийн дансны үлдэгдэл 4,744.3 тэрбум төгрөгөөс гадаад валютаарх үлдэгдэл 1,009.1 тэрбум төгрөг байна. Үүнээс 418.5 тэрбум төгрөг нь төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, 441.2 тэрбум төгрөг нь төрийн сан, 118.3 тэрбум төгрөг нь төсөл, сан, 31.1 тэрбум төгрөг нь төсөвт байгууллагын үлдэгдэл байна.

Арилжааны банканд байршиж буй нийт 2,662.9 тэрбум төгрөгийн 53.1 хувь нь төсөл, сангийн, 40.5 хувь нь төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн, 6.4 хувь нь төсөвт байгууллага, төрийн сангийн үлдэгдэл байна.

Хүснэгт №3. Хадгаламж дахь мөнгөн хөрөнгө /сая төгрөг/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Нийгмийн даатгалын сан	484,280.0	10,000.0	-474,280.0	1.9
Эрүүл мэндийн даатгалын сан	233,000.0	350,000.0	117,000.0	68.2
Эрдэнэс Тавантолгой ХК	150,000.0	0.0	-150,000.0	0.0
Монгол Улсын Хөгжлийн банк ХХК	145,495.0	15,491.0	-130,004.0	3.0
Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	115,081.4	18,155.2	-96,926.2	3.5
Төрийн банк ХХК	55,013.6	0.0	-55,013.6	0.0
Зээлийн батлан даалтын сан	0.0	68,196.2	68,196.2	13.3
Монгол Улсын Их Сургууль	0.0	28,413.1	28,413.1	5.5
Бусад	23,378.4	22,764.3	-614.1	4.4
Дүн	1,206,248.4	513,019.8	-693,228.6	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хадгаламж дахь мөнгөн хөрөнгийн өөрчлөлтөд Нийгмийн даатгалын сан 474.3 тэрбум, Эрдэнэс Тавантолгой ХК 150.0 тэрбум, Монгол Улсын Хөгжлийн банк ХХК 130.0 тэрбум, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ 96.9 тэрбум, Төрийн банк ХХК 55.0 тэрбум төгрөгийн хадгаламжийг татсан, Эрүүл мэндийн даатгалын сан 117.0 тэрбум төгрөгөөр хадгаламжийг нэмэгдүүлсэн, Зээлийн батлан даалтын сан

68.2 тэрбум, МУИС 28.4 тэрбум төгрөгийн хадгаламжийг тус тус шинээр байршуулсан нь голлон нөлөөлсөн байна.

Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 798.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 493.5 тэрбум болж, 305.1 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4. Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгө /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт(-)
Банканд байгаа мөнгөн хөрөнгө	746,011.6	466,820.8	-279,190.8
Төгрөг	38,765.6	43,457.0	4,691.4
Төрийн сан	29,343.8	33,837.8	4,494.0
Монголбанк	8,688.2	8,858.6	170.4
Арилжааны банк	733.6	760.6	27.0
Гадаад валют	707,246.0	423,363.8	-283,882.2
Монголбанк	707,246.0	423,363.8	-283,882.2
Замд яваа мөнгөн хөрөнгө	52,616.4	26,727.3	-25,889.1
Дүн	798,628.0	493,548.1	-305,079.9

Эх сурвалж: Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 8.8 хувийг төгрөгийн харилцах, 85.8 хувийг гадаад валютын харилцах, 5.4 хувийг замд яваа мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл эзэлж байна.

Валютын харилцах дансны үлдэгдлийн 250.0 тэрбум төгрөг нь улсын төсвийн дансны, 170.9 тэрбум төгрөг нь төсөл, хөтөлбөрийн, 2.5 тэрбум төгрөг нь дамжуулан зээлийн эргэн төлөлтийн мөнгөн хөрөнгө байна.

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 798.6 тэрбум, тайлант онд үйл ажиллагааны орлогоос 9,401.0 тэрбум, зээлийн эргэн төлөлтөөс 173.3 тэрбум, зээлийн эх үүсвэрээс 1,515.5 тэрбум, нийт 11,089.8 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, урсгал зардалд 8,049.5 тэрбум, хөрөнгө оруулалтын зардалд 1,414.6 тэрбум, зээлийн эргэн төлөлт, ханшийн зөрүүд 1,930.8 тэрбум, нийт 11,394.9 тэрбум төгрөгийг зарцуулж, оны эцэст 493.5 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төв төрийн сан улсын төсвийн зарлагын эх үүсвэрийн дутагдал 1,451.5 тэрбум төгрөгийг төрийн сангийн нэгдсэн данснаас бүрдүүлж санхүүжүүлсэн байна.

Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 1,262.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 732.4 тэрбум болж, 530.2 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5. Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Банканд байгаа бэлэн мөнгө	778,306.2	722,313.6	-55,992.6	98.6
Төрийн сангийн харилцах	62,768.8	16,987.8	-45,781.0	2.3
Нэмэлт санхүүжилт	22.3	45.8	23.5	0.0
Арилжааны банкны харилцах	715,515.1	705,280.0	-10,235.1	96.3
Хадгаламж	484,280.0	10,000.0	-474,280.0	1.4
Замд яваа мөнгөн хөрөнгө	0.0	59.6	59.6	0.0
Дүн	1,262,586.2	732,373.2	-530,213.0	100.0
Үүнээс, сангийн төрлөөр				
Тэтгэврийн даатгал	381,121.2	249,115.2	-132,006.0	34.0
Тэтгэмжийн даатгал	61,025.1	40,662.7	-20,362.4	5.6
ҮОМШӨ-ний даатгал	707,808.6	380,753.7	-327,054.9	52.0
Ажилгүйдлийн даатгал	101,471.1	42,614.6	-58,856.5	5.8
Эрүүл мэндийн даатгал	7,776.3	9,467.7	1,691.4	1.3
Бусад	3,383.9	9,759.3	6,375.4	1.3
Дүн	1,262,586.2	732,373.2	-530,213.0	100.0

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос буурсан нь дэлхий нийтийг хамарсан Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуульд заасны дагуу албан журмын болон сайн дурын даатгуулагчдаас төлөх нийт 642.6 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг чөлөөлсөн нь нөлөөлжээ.

Мөнгөн хадгаламжийн эхний үлдэгдэл 484.3 тэрбум төгрөгөөс 10.0 тэрбум төгрөг болж буурсан нь Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд заасны дагуу 694.7 тэрбум төгрөгийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд хөнгөлөлттэй хүүтэй байршуулж, хугацаа дууссан хадгаламжаа харилцах данс руу шилжүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт №6. Хадгаламжийн хүү

Монголбанкны бодлогын хүү		НДҮЗ-ийн тогтоол	
Огноо	Хүүгийн хэмжээ	Огноо, дугаар	Хүүгийн хэмжээ
2020.03.12	10.0	2020.03.02	6.0
2020.04.14	9.0		
2020.09.15	8.0		
2020.11.24	6.0		

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны 03 дугаар тогтоолоор арилжааны банкуудад хөнгөлөлттэй хүүтэй байршуулах мөнгөн хадгаламжийн дүнг 694.7 тэрбум төгрөгөөр, хүүгийн хэмжээг 6.0 хувиар баталжээ.

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийгмийн даатгалын ерөнхий газар нь Монголбанк арилжааны банкуудаас “Эрдэнэс бонд”-ыг худалдан авах хүртэл 2-10 сарын хугацаанд арилжааны 7 банканд 694.7 тэрбум төгрөгийг 6.0 хувийн хүүтэй байршуулсан байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 557.5 тэрбум, эцсийн үлдэгдэл 617.2 тэрбум болж, 59.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7. Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт(-)	Дүнд эзлэх хувь
Харилцах данс	324,520.3	267,256.2	-57,264.1	43.3
Төрийн сангийн харилцах	35,693.5	108,695.2	73,001.7	17.6
Арилжааны банкны харилцах	288,826.8	158,561.0	-130,265.8	25.7
Хадгаламж	233,000.0	350,000.0	117,000.0	56.7
Дүн	557,520.3	617,256.2	59,735.9	100.0

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

ЭМДҮЗ-ийн "Эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг дансанд байршуулах тухай" 2020 оны 03 дугаар тогтоолоор 117.0 тэрбум төгрөгийг хадгаламжийн дансанд нэмж байршуулжээ.

Хүснэгт №8. Арилжааны банкнууд дахь хадгаламж /сая төгрөг/

№	Банкны нэр	Дундаж хүү	Эцсийн үлдэгдэл	Дүнд эзлэх хувь
1	Капитрон банк	12.0	10,000.0	2.9
2	Хас банк	11.8	20,000.0	5.7
3	Голомт банк	12.1	40,000.0	11.4
4	Төрийн банк	13.0	45,000.0	12.8
5	Хаан банк	12.1	115,000.0	32.9
6	Худалдаа хөгжлийн банк	12.4	120,000.0	34.3
	Дүн		350,000.0	100.0

Тайлант онд сангийн мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлээс 350.0 тэрбум төгрөгийн хадгаламжийг арилжааны банканд байршуулж, хүүгийн орлого 55.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт:

- Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар буурсан нэр бүхий 2 банкны харилцах дансанд байршиж байгаа 54.5 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгөд эрсдэл үүссэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 3,530.2 тэрбум, эцсийн үлдэгдэл 3,142.0 тэрбум болж, 388.2 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №9. Улс, орон нутгийн ТЕЗ-ийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	59,787.4	56,028.3	-3,759.1	1.8
Банканд байгаа бэлэн мөнгө	2,966,670.4	2,900,496.9	-66,173.5	92.3
Замд яваа мөнгөн хөрөнгө	14,783.5	32,481.3	17,697.8	1.0
Хадгаламж	488,968.4	153,019.8	-335,948.6	4.9
Дүн	3,530,209.7	3,142,026.3	-388,183.4	100.0
Үүнээс,				
УТЕЗ	2,915,158.4	2,860,256.4	-54,902.0	91.0
ОНТЕЗ	615,051.3	281,769.9	-333,281.4	9.0
Дүн	3,530,209.7	3,142,026.3	-388,183.4	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2019 оны 430 дугаар тогтоолын дагуу барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан хэрэгжээгүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн үлдэгдэл 50.9 тэрбум төгрөг байна.

Хүснэгт №10. Барьцаа дансанд шилжүүлсэн хөрөнгө оруулалтын санхүүжилт /сая төгрөг/

№	Төсвийн ерөнхийлөн захирагчид	Барьцаа дансанд шилжүүлсэн
1	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	1,277.3
2	Сангийн сайд	21,059.3
3	Эрүүл мэндийн сайд	1,148.2
4	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	191.0
5	Барилга, хот байгуулалтын сайд	1,353.1
6	Боловсрол, шинжлэх ухааны сайд	21,577.8
7	Зам, тээврийн хөгжлийн сайд	2,995.7
8	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	175.1
9	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	1,160.9
	Дүн	50,938.5

Эх сурвалж: Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын газраас ирүүлсэн судалгаа

Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 2,915.2 тэрбум, эцсийн үлдэгдэл 2,860.3 тэрбум төгрөг болж, 54.9 тэрбум төгрөгөөр буурсан ба үлдэгдлийн 86.5 хувийг банк дахь харилцах данс, 11.2 хувийг хадгаламж, 1.2 хувийг касст байгаа, 1.1 хувийг замд яваа мөнгөн хөрөнгө эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Хөрөнгө оруулалтын барьцаа дансанд Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоолоор өмнөх онд хэрэгжээгүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн үлдэгдэл 50.9 тэрбум төгрөг;
- Улсын төсөвт төвлөрүүлбэл зохих ногдол ашиг, техникийн хяналтын зардлаас хэмнэгдсэн хөрөнгө, тэмдэгтийн хураамж, хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийн үлдэгдэл, түрээсийн орлого, дэнчин, төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй 10.0 тэрбум төгрөг /МУЕС 3.7 тэрбум, ЗГХЭГ 3.1 тэрбум, ЗТХЯ 2.0 тэрбум, БОАЖЯ 1.1 тэрбум, бусад ТЕЗ 0.1 тэрбум/;

- Мөнгөн кассын үйл ажиллагааны журмыг зөрчсөн, мөнгөн гүйлгээний тайланг зөрүүтэй илэрхийлсэн, кассын үлдэгдлийг төвлөрүүлээгүй, кассын зарлагын гүйлгээ хийх дээд хязгаарыг хэтрүүлсэн 6.6 тэрбум төгрөг /БШУЯ 3.7 тэрбум, МУШС 1.3 тэрбум, УУХҮЯ 1.2 тэрбум, ЗТХЯ 0.3 тэрбум, бусад ТЕЗ 0.1 тэрбум/;
- Орлогын төлөвлөгөө батлуулаагүй, дутуу бүрдүүлсэн, зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан 4.6 тэрбум төгрөг /ЭМЯ 2.3 тэрбум, УУХҮЯ 1.0 тэрбум, ЗТХЯ 0.8 тэрбум, МУШС 0.5 тэрбум/;
- Ажилчдын цалин, урамшуулал, нэмэгдлийг зөрүүтэй тооцож олгосон 4.7 тэрбум төгрөг /ЭМЯ 2.5 тэрбум, ЗТХЯ 0.7 тэрбум, ЗГХЭГ 0.6 тэрбум, УУХҮЯ 0.4 тэрбум, БШУЯ 0.4 тэрбум, МУШС 0.1 тэрбум/;
- Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн 4.1 тэрбум төгрөг /ХЗДХЯ 1.8 тэрбум, ЭХЯ 0.9 тэрбум, ЭМЯ 0.7 тэрбум, МУШС 0.5 тэрбум, Соёлын яам 0.1 тэрбум, бусад ТЕЗ 0.1 тэрбум/;
- Төлбөрийн чадвар нь буурсан нэр бүхий банкуудад нийт 314.7 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгө байршиж байна.

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 615.0 тэрбум, эцсийн үлдэгдэл 281.7 тэрбум төгрөг болж, 333.3 тэрбум төгрөгөөр буурсан ба үлдэгдлийн 96.3 хувийг банк дахь харилцах, 3.5 хувийг замд яваа, 0.2 хувийг кассад байгаа мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл эзэлж байна.

Орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт 212.7 тэрбум, Төрийн санд 31.0 тэрбум, төсөвт байгууллагад 25.7 тэрбум, төсөл сангуудад 12.3 тэрбум, нийт 281.7 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн 16.6 тэрбум төгрөг /Нийслэл 13.0 тэрбум, Говь-Алтай 2.4 тэрбум, Архангай 0.6 тэрбум, Өвөрхангай 0.2 тэрбум, Орхон 0.1 тэрбум, Сүхбаатар 0.1 тэрбум, бусад ОНТЕЗ 0.2 тэрбум/;
- Мөнгөн кассын үйл ажиллагааны журмыг зөрчсөн, мөнгөн гүйлгээний тайланг зөрүүтэй илэрхийлсэн, байгууллагын эд хариуцагчийн дансаар бэлэн мөнгөний гүйлгээ хийсэн, кассын зарлагын гүйлгээ хийх дээд хязгаарыг хэтрүүлсэн 0.9 тэрбум төгрөг /Өвөрхангай 0.3 тэрбум, Нийслэл 0.3 тэрбум, Дархан-Уул 0.1 тэрбум, бусад ОНТЕЗ 0.2 тэрбум/;
- Төсвийг зориулалт бус, үр ашиггүй зарцуулсан, орлогын төлөвлөгөө батлуулаагүй, дутуу бүрдүүлсэн, зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан 0.8 тэрбум төгрөг /Хэнтий 0.3 тэрбум, Говь-Алтай 0.3 тэрбум, Сүхбаатар 0.1 тэрбум, бусад ОНТЕЗ 0.1 тэрбум/;
- Ажилчдын цалин, урамшуулал, нэмэгдлийг зөрүүтэй тооцож олгосон 0.7 тэрбум төгрөг /Ховд 0.3 тэрбум, Говь-Алтай 0.3 тэрбум, бусад ОНТЕЗ 0.1 тэрбум/;
- Төсөвт төвлөрүүлбэл зохих түрээсийн орлого, төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 0.1 тэрбум төгрөг байна.

Хоёр. БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны эхний үлдэгдэл 763.3 тэрбум, эцсийн үлдэгдэл 896.7 тэрбум болж, 133.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №11. Богино хугацаат хөрөнгө оруулалт, байгууллагаар /сая төгрөг/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төрийн банк ХХК	728,104.1	887,904.5	159,800.4	99.0
МИАТ ТӨХК	34,147.4	7,961.7	-26,185.7	0.9
Боловсролын зээлийн сан	1,023.7	848.7	-175.0	0.1
Монголын хөрөнгийн бирж ХХК	1.0	0.0	-1.0	0.0
Дүн	763,276.2	896,714.9	133,438.7	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн банк ХХК нь Монголбанкны 3 хүртэлх сарын хугацаатай 159.8 тэрбум төгрөгийн үнэт цаас худалдан авсан нь богино хугацаат хөрөнгө оруулалт өсөхөд голлон нөлөөлжээ.

МИАТ ТӨХК арилжааны банк дахь мөнгөн хадгаламжийн үлдэгдэл 26.2 тэрбум төгрөгийг харилцах дансанд шилжүүлэн авсан, Боловсролын зээлийн сангийн арилжааны банкаар дамжуулан олгосон хөнгөлөлттэй зээлийн 0.2 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийгдсэн байна.

Гурав. АВЛАГА

Авлага дансны эхний үлдэгдэл 5,569.3 тэрбум, эцсийн үлдэгдэл 5,486.4 тэрбум болж, 82.9 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №12. Авлага дансны ангилал, байгууллагын төрлөөр /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажиллагсадтай холбогдсон авлага	2,565.4	3,217.6	652.2	0.1
Төлбөртэй үйлчилгээний авлага	362,428.1	314,486.9	-47,941.2	5.7
Татаас, санхүүжилтийн авлага	28,282.2	719,717.6	691,435.4	13.1
Зээлийн хүүгийн авлага	148,846.9	322,546.4	173,699.5	5.9
Дансны авлага /ТӨҮГ/	1,346,876.5	450,036.0	-896,840.5	8.2
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	53,804.6	164,327.7	110,523.1	3.0
Бусад авлага	1,113,299.4	1,252,302.1	139,002.7	22.8
Зээлийн авлага	2,513,226.2	2,259,821.8	-253,404.4	41.2
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	1,155,825.8	1,304,691.5	148,865.7	
Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн авлага	1,357,400.4	955,130.3	-402,270.1	
Дүн	5,569,329.3	5,486,456.1	-82,873.2	100.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>				
ТӨҮГ болон ОНӨҮГ	2,062,896.0	1,644,495.3	-418,400.7	30.0
Төрийн сан	1,726,747.7	1,207,546.6	-519,201.1	22.0
Төсөвт байгууллага	1,221,478.0	1,143,455.3	-78,022.7	20.8
Төсөл/Сан	558,207.6	1,490,958.9	932,751.3	27.2
Дүн	5,569,329.3	5,486,456.1	-82,873.2	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны нийт үлдэгдлийн 8.8 хувь буюу 481.1 тэрбум төгрөг нь дампуурсан банк, хадгаламж, зээлийн хоршооноос авах авлага байна.

Хүснэгт №13. Дампуурсан банкнаас авах авлага төсөв захирагчдаар: /сая төгрөг/

Байгууллага	УТЕЗ	ОНТЕЗ	Нийт
Азийн хөрөнгө оруулалтын банк	19.6	-	19.6
Анод банк	21,656.8	0.3	21,657.1
ХОТШ банк	1,846.9	127.2	1,974.1
Сэргээн босголт банк	2,088.1	19.9	2,108.0
Эксим банк	753.2	-	753.2
Ард, даатгал банк	985.1	22.7	1,007.8
Зоос банк	58,484.7	-	58,484.7
Хадгаламж банк	2.7	-	2.7
Капитал банк	362,170.5	12,305.8	374,476.3
Хадгаламж зээлийн хоршоо	20,600.7	-	20,600.7
Дүн	468,608.3	12,475.9	481,084.2

Эх сурвалж: Төсөв захирагчдаас ирүүлсэн судалгааны нэгтгэл, Капитал банкны эрх хүлээн авагчаас ирүүлсэн 2021 оны 909 дугаар бүхий албан бичиг

Аудитын илрүүлэлт:

- Татан буугдсан банк, хадгаламж зээлийн хоршоодын нийт 481.1 тэрбум төгрөгийн олон жилийн насжилттай, эрсдэлтэй авлагын үлдэгдэл;
- Засгийн газрын 2017 оны 199 дүгээр тогтоолоор баталсан “Гэр хорооллын өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журам”-ын дагуу санхүүжилтийг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс Эрчим хүчний салбарын 14 төрийн өмчит компанид 2017-2020 онд 7.3 тэрбум төгрөгийн авлага хуримтлагдсан байна.

Төв төрийн сангийн авлага

Төв төрийн сангийн авлагын эхний үлдэгдэл 1,721.3 тэрбум, эцсийн үлдэгдэл 1,202.2 тэрбум төгрөг болж, 519.1 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №14. Төв төрийн сангийн авлага /сая төгрөг/

Харилцагч байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Зээлийн хүүгийн авлага	1,159.4	4,011.8	2,852.4
Бусад авлага	317,238.2	238,238.4	-78,999.8
Зээлийн авлага	1,402,871.8	959,946.0	-442,925.8
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	58,353.3	19,821.9	-38,531.4
Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн авлага	1,344,518.5	940,124.1	-404,394.4
Дүн	1,721,269.4	1,202,196.2	-519,073.2

Эх сурвалж: Төв төрийн сангийн 2020 оны санхүүгийн тайлан

Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлагын эхний үлдэгдэл 1,357.4 тэрбум, эцсийн үлдэгдэл 955.1 тэрбум төгрөг болж, 402.3 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №15. Дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
ЗГ-ын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	573,580.7	417,833.9	-155,746.8
Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон	530,788.1	15,732.8	-515,055.3
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон	253,031.6	521,563.6	268,532.0
Дүн	1,357,400.4	955,130.3	-402,270.1
Үүнээс:			
Гадаад зээлээс дамжуулсан зээл	1,344,518.5	940,124.1	-404,394.4
Бусад дамжуулан зээл	12,881.9	15,006.2	2,124.3
Дүн	1,357,400.4	955,130.3	-402,270.1

Эх сурвалж: Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн авлагын бууралтад тайлант онд авлага барагдуулах ажлыг эрчимжүүлж 139.4 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгдсэн, зарим төрийн өмчит хуулийн этгээдийн өглөгийг бүртгэлд тусгуулж, нэгтгэсэн тайланд цэвэр дүнгээр илэрхийлсэн нь голлон нөлөөлжээ.

Төв төрийн сангийн гадаад эх үүсвэрээс дамжуулан зээлдүүлсэн 577.0 тэрбум төгрөгийн үлдэгдэл бүхий 118 гэрээг харилцагч байгууллагатай төгрөгөөр байгуулснаас /2015 оноос өмнө/ тайлант оны байдлаар ханшийн зөрүүгээс төсөвт 50.8 тэрбум төгрөгийн дарамт учруулсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд 1991-1996 онуудад хувийн хэвшлийн 89 байгууллагад олгосон Төв төрийн сангийн 232.4 тэрбум төгрөгийн олон жилийн насжилттай, тооцоо нийлээгүй дамжуулан зээлийн найдваргүй авлага бүртгэлтэй байна. Үүнээс, шүүхийн шийдвэр гарсан, хөөн хэлэлцэх хугацаа дууссан 46.3 тэрбум төгрөгийн 19 зээлийн үлдэгдлийг шийдвэрлээгүй;
- Ашиглалтад орсон Налайх-Чойр чиглэлийн 220 км авто зам, Дархан-Эрдэнэт чиглэлийн авто замтай холбоотой дамжуулан зээлийн 101.2 тэрбум төгрөгийн авлагыг шийдвэрлээгүй;
- Засгийн газрын 2009 оны 284 дүгээр тогтоол, Төрийн өмчийн хорооны 2010 оны 169 дүгээр тогтоолоор Дэлхийн банк болон Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн Тээвэр хөгжлийн төсөл, Авто зам хөгжүүлэх хоёр дахь төслийн хүрээнд авто зам, засвар арчлалтын 18 төрийн өмчит хувьцаат компаниудад 1996-2005 онд нийлүүлсэн машин механизм тоног төхөөрөмжийн нийт 6.1 тэрбум төгрөгийн урт хугацаат зээлийн дүнгээр дүрмийн санг нэмэгдүүлэх шийдвэрийг хэрэгжүүлээгүй, Төв төрийн сангийн санхүүгийн тайланд дамжуулан зээлийн авлагаас хасаагүй;

- Засгийн газрын 2005 оны 262 дугаар тогтоолоор Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжих Тээвэр сэргээх төслийн хүрээнд 1995-1997 онуудад зээлийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн 44 автобус, 9 троллейбус, тэдгээрийн сэлбэг хэрэгслийн нийт 9.5 сая ам.долларыг төсвийн хөрөнгө оруулалтад тооцох шийдвэр гарсан боловч 26.8 тэрбум төгрөгийн авлага эзэн холбогдоггүй;
- Төв төрийн сангийн санхүүгийн тайланд бүртгэлтэй 321.7 тэрбум төгрөгийн дамжуулан зээлийн авлагыг харилцагч байгууллагууд санхүүгийн тайландаа өр төлбөрөөр бүртгээгүй, 68.8 тэрбум төгрөгийн ханшийн зөрүүгээр тооцоо зөрснөөс авлагын данс илүү илэрхийлэгдсэн;

Төсөвт байгууллагын авлага

Төсөвт байгууллагуудын авлагын дансны эхний үлдэгдэл 1,221.4 тэрбум, эцсийн үлдэгдэл 1,143.4 тэрбум болж, 78.0 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №16. Төсөвт байгууллагын авлага /сая төгрөг/

Төсөвт байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Улсын төсвийн ерөнхийлөн захирагчид	1,079,734.1	1,002,650.3	-77,083.8
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчид	141,743.8	140,805.0	-938.8
Дүн	1,221,477.9	1,143,455.3	-78,022.6

Эх сурвалж: Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсөвт байгууллагын авлагын үлдэгдэлд ХХААХҮЯ 277.4 тэрбум, БШУЯ 267.3 тэрбум, Сангийн яам 217.4 тэрбум, ХНХЯ 93.5 тэрбум, ХЗДХЯ 77.1 тэрбум, ОНТЕЗ 140.8 тэрбум, бусад УТЕЗ 69.9 тэрбум төгрөг байна.

Аудитын илрүүлэлт:

Улсын болон орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын авлагатай холбоотой нийт 109.0 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Олон жилийн насжилттай, найдваргүй болох эрсдэлтэй 58.5 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулаагүй /ХНХЯ 21.9 тэрбум, ХХААХҮЯ 2.0 тэрбум, ЗТХЯ 4.5 тэрбум, УУХҮЯ 0.4 тэрбум, БШУЯ 0.3 тэрбум төгрөг, Сангийн яам 0.1 тэрбум, ОНТЕЗ 29.3 тэрбум/;
- Тооцоо нийлж баталгаажуулаагүй 165.8 тэрбум төгрөгийн авлага / ХХААХҮЯ 156.8 тэрбум, ГХЯ 1.9 тэрбум, УУХҮЯ 1.7 тэрбум, ХНХЯ 1.6 тэрбум, ЗГХЭГ 0.3 тэрбум, ЭХЯ 0.1 тэрбум, ОНТЕЗ 3.4 тэрбум/;
- Нягтлан бодох бүртгэлд зөрүүтэй тайлагнасан болон бүртгэлд тусгаагүй 10.7 тэрбум төгрөгийн авлага /ЗТХЯ 2.3 тэрбум, ХНХЯ 1.7 тэрбум, ХХААХҮЯ 1.0 тэрбум, БШУЯ 0.5 тэрбум, УУХҮЯ 0.4 тэрбум, МУШС 0.4 тэрбум, Сангийн яам 0.3 тэрбум, МУЕС 0.2 тэрбум, ЭХЯ 0.3 тэрбум, ОНТЕЗ 3.6 тэрбум/;
- Сум хөгжүүлэх сангийн нийт авлагын 28.3 хувь буюу 24.7 тэрбум төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлээгүй, 39.9 хувь буюу 34.8 тэрбум төгрөгийн авлага хугацаа хэтэрсэн;
- Орон нутгийн хөгжлийн сангийн нийт авлагын 27.4 хувь буюу 1.4 тэрбум төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, 37.2 хувь буюу 1.9 тэрбум төгрөгийн авлага хугацаа хэтэрсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлага

Авлагын эхний үлдэгдэл 2,062.9 тэрбум, эцсийн үлдэгдэл 1,644.5 тэрбум болж, 418.4 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №17. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлага /сая төгрөг/

Өмчийн хэлбэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төрийн өмчит хуулийн этгээд	1,973,890.7	1,420,438.3	-553,452.4
Орон нутгийн өмчит хуулийн этгээд	89,005.2	224,057.0	135,051.8
Дүн	2,062,895.9	1,644,495.3	-418,400.6

Эх сурвалж: Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн авлагын үлдэгдэлд Сангийн яам 748.5 тэрбум, УУХҮЯ 227.4 тэрбум, БХБЯ 155.7 тэрбум, ОНӨҮГ 89.0 тэрбум, бусад ТӨҮГ 423.9 тэрбум төгрөг байна.

Монгол Улсын Хөгжлийн банк ХХК дотоодын арилжааны банкнуудад байршуулсан 320.1 тэрбум төгрөгийн хадгаламжаа татсан болон гадаадын банканд байршуулсан 438.8 тэрбум төгрөгийн хадгаламжийг урт хугацаат хадгаламж дансанд шилжүүлэн бүртгэснээс шалтгаалж төрийн өмчит үйлдвэрийн газрын авлага буурсан байна.

Нийслэлийн Орон сууцны корпораци ХК-ийн түрээслээд өмчлөх нөхцөлтэй орон сууцжуулах хөтөлбөрийн хүрээнд үүссэн иргэдээс авах авлага 113.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын авлага нэмэгдэхэд голлон нөлөөлсөн байна.

Нийгмийн даатгалын сангийн авлага

Нийгмийн даатгалын сангийн авлагын эхний үлдэгдэл 251.4 тэрбум, эцсийн үлдэгдэл 1,001.4 тэрбум болж, 750.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №18. Авлагын дансны үлдэгдэл, байгууллагын төрлөөр /сая.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт(-)	Дүнд эзлэх хувь
Төлбөртэй үйлчилгээний авлага	138,273.0	197,168.7	58,895.7	19.7
Татаас, санхүүжилтийн авлага	0.0	691,612.9	691,612.9	69.1
Байгууллагаас авах авлага	113,071.9	112,575.7	-496.2	11.2
Хувь хүмүүсээс авах авлага	66.3	86.0	19.7	0.0
Дүн	251,411.2	1,001,443.3	750,032.1	100.0

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд албан журмын даатгуулагчийн 619.1 тэрбум, сайн дурын даатгуулагчийн 23.5 тэрбум, нийгмийн даатгалын шимтгэлийн чөлөөлөлт болон ажилгүйдлийн дэмжлэгийн 39.9 тэрбум, зарим иргэдийн тэтгэврийн зөрүү 9.1 тэрбум, нийт 691.6 тэрбум төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 172.4 тэрбум, эцсийн үлдэгдэл 167.5 тэрбум болж, 4.9 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №19. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.0	0.9	-0.9	0.0
Татаас, санхүүжилтийн авлага	26,529.8	26,495.3	-34.50	15.8
Төлбөртэй үйлчилгээний авлага	0.0	137.8	137.8	0.1
Бусад авлага	145,845.2	140,893.9	-4,951.3	84.1
Дүн	172,375.0	167,527.9	-4,847.1	100.0

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Эрүүл мэндийн даатгалын сангийн авлагын үлдэгдэлд татан буугдсан Капитал банкны эрх хүлээн авагчаас авах 135.2 тэрбум, 2018-2019 онд үүссэн төр хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэл 26.5 тэрбум, 2018 онд НДЕГ-аас шилжиж ирсэн ХНХЯ-аас авах 4.4 тэрбум, “Эрүүл хүүхэд, эрүүл шүд хөтөлбөр”-ийн хүрээнд бий болсон дүүрэг, аймгуудын эрүүл мэндийн байгууллагууд болон бусдаас авах 1.4 тэрбум төгрөг байна.

Аудитын илрүүлэлт:

- Өмнөх ондуудад үүссэн төр төлбөрийг нь хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 26.5 тэрбум төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй.

Дөрөв. УРЬДЧИЛГАА

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 1,186.4 тэрбум, эцсийн үлдэгдэл 2,295.6 тэрбум болж, 1,109.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №20. Урьдчилгаа данс байгууллагын төрлөөр /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төсөвт байгууллага	290,965.2	1,384,037.0	1,093,071.8	60.3
Төрийн сан	64,995.2	0.0	-64,995.2	0.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	763,034.0	666,165.8	-96,868.2	29.0
Төсөл/сан	67,445.0	245,396.8	177,951.8	10.7
Дүн	1,186,439.4	2,295,599.6	1,109,160.2	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 1,109.2 тэрбум төгрөгөөр өсөхөд Эрдэнэс Монгол ХХК Эрчим хүчний экспортын Шивээ энержи цогцолбор төсөлд 252.5 тэрбум, Монголросцветмет ТӨҮГ Монголын далд уурхайн музейн, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв төслийн нэгжид 477.4 тэрбум, Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл 209.8 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөрийг шилжүүлсэн нь голлон нөлөөлжээ.

Аудитын илрүүлэлт:

- УУХҮЯ нь 2016-2019 онуудад хийгдсэн геологийн судалгааны ажлын гэрээг дүгнээгүйгээс 10.0 тэрбум төгрөгийн хуримтлагдсан урьдчилгаа төлбөрийн үлдэгдэлтэй;
- ОББҮХ-ны өмнөх онуудад байгуулсан хэрэгжих хугацаа хэтэрсэн 6.3 тэрбум төгрөгийн 18 гэрээний үүргийн биелэлтийг дүгнээгүй, тооцоо нийлээгүй;
- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ урьдчилж төлсөн тооцоо дансны 5.2 тэрбум төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл тайлант онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаар дамжуулан хэрэгжүүлсэн бичил зээлийн төслийн санхүүжилтийн үлдэгдэл 5.2 тэрбум төгрөгийг урьдчилгаа тооцоогоор тайлагнаагүй;
- Монголын төмөр зам ТӨХК-ийн Зэвсэгт хүчний бүтээн байгуулалт дэмжлэгийн газарт олгосон урьдчилгаа дансны бүртгэл, тооцоо нийлсэн актын дүнгээс 0.6 тэрбум төгрөгөөр зөрүүтэй.

Тав. БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 2,039.5 тэрбум, эцсийн үлдэгдэл 2,735.2 тэрбум болж, 695.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №21. Бараа материал данс байгууллагын төрлөөр /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ТӨҮГ болон ОНӨҮГ	1,261,577.7	1,748,723.6	487,145.9	70.0
Төсөвт байгууллага	772,614.4	940,945.4	168,331.0	24.2
Төсөл/сан	5,310.2	45,538.8	40,228.6	5.8
Дүн	2,039,502.3	2,735,207.8	695,705.5	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн бараа материалын үлдэгдэл өссөн нь Монголын төмөр зам ТӨХК 395.4 тэрбум, Эрдэнэс Тавантолгой ХК 24.1 тэрбум, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ 16.3 тэрбум, Тавантолгой түлш ХХК 13.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Улсын болон орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланд бараа материалтай холбоотой нийт 70.9 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна.

- Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчил 16.2 тэрбум төгрөг; /УУХҮЯ 10.4 тэрбум, ХЗДХЯ 1.8 тэрбум, ЭХЯ 1.6 тэрбум, Говь-Алтай 0.9 тэрбум, ЗТХЯ 0.6 тэрбум, ХХААХҮЯ 0.4 тэрбум, ЗГХЭГ 0.4 тэрбум, МУДШ 0.1 тэрбум/
- Бараа материалын дансны ангилал буруу бүртгэсэн, үр ашиггүй зарцуулсан, нөөц үүсгэсэн, шууд зардалд тусгасан, анхан шатны баримтын бүрдэл дутуу зэрэг бүртгэл тайлагналтай холбоотой 53.1 тэрбум төгрөг /ЭМЯ 5.2 тэрбум, ЭХЯ 1.0 тэрбум, ЗТХЯ 0.9 тэрбум, УУХҮЯ 0.5 тэрбум, ХЗДХЯ 0.3 тэрбум, БШУЯ 0.2 тэрбум, БОАЖЯ 0.1 тэрбум, Өвөрхангай 22.9 тэрбум, Увс 12.8 тэрбум, Хэнтий 4.3 тэрбум, Нийслэл 1.3 тэрбум, Баян-Өлгий 1.1 тэрбум, Орхон 0.6 тэрбум, Ховд 0.4 тэрбум, Говь-Алтай 0.4 тэрбум, Архангай 0.3 тэрбум, Баянхонгор 0.1 тэрбум, Сэлэнгэ 0.1 тэрбум, Сүхбаатар 0.2 тэрбум, Дархан 0.2 тэрбум, Говьсүмбэр 0.2 тэрбум/
- Ковид-19 цар тахлын үед ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаас бэлтгэсэн 1.6 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг бодитоор хүлээн аваагүй, тооцоо нийлсэн актгүй хөрөнгийг бүртгэлд тусгасан.

Зургаа. БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

Бусад эргэлтийн хөрөнгийн эхний үлдэгдэл 5,109.9 тэрбум, эцсийн үлдэгдэл 6,254.3 тэрбум болж, 1,144.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Бусад эргэлтийн хөрөнгө дансанд улсын комисс хүлээж аваагүй, гэрээнд заасан хугацаандаа ашиглалтад ороогүй, ТӨБЗГ-ын тогтоол гараагүй, гэрээний үүргийн хэрэгжилтийг хангаагүй, санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдээгүй, эд хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлээгүй улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээний 1,866.6 тэрбум төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй /Нийслэл 800.5 тэрбум, ЗГХЭГ 351.0 тэрбум, БХБЯ 203.5 тэрбум, ЭМЯ 217.0 тэрбум, ЭХЯ 136.0 тэрбум, Сангийн яам 76.2 тэрбум, МҮЕС 67.2 тэрбум, ХНХЯ 7.6 тэрбум, УУХҮЯ 5.1 тэрбум, УЕП 2.4 тэрбум, ХЗДХЯ 0.1 тэрбум/.

Долоо. УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны эхний үлдэгдэл 8,540.9 тэрбум, эцсийн үлдэгдэл 10,040.4 тэрбум болж, 1,499.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №22. Урт хугацаат хөрөнгө оруулалт, байгууллагын төрлөөр /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Урт хугацаат хадгаламж	67,467.2	490,969.2	423,502.0	4.9
Үнэт цаас	1,693,048.2	2,329,124.3	636,076.1	23.2
Урт хугацаат зээл	6,780,397.7	7,220,309.7	439,912.0	71.9
Дүн	8,540,913.1	10,040,403.2	1,499,490.1	100.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр харуулбал:</i>				
Төсөвт байгууллага	47,341.4	15,897.6	-31,443.8	0.2
Төрийн сан	2,133,815.8	2,297,369.0	163,553.2	22.9
ТӨҮГ болон ОНӨҮГ	6,359,755.9	7,727,136.6	1,367,380.7	76.9
Дүн	8,540,913.1	10,040,403.2	1,499,490.1	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урт хугацаат хөрөнгө оруулалтын 0.2 хувийг төсвийн байгууллагын, 22.9 хувийг Засгийн газрын, 76.9 хувийг төрийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн хадгаламж, үнэт цаас, урт хугацаат зээлээрх хөрөнгө оруулалт эзэлж байна.

Урт хугацаат хадгаламжийн үлдэгдэлд Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-ийн гадаад банканд байршуулсан 439.0 тэрбум, Үндэсний давхар даатгал ХХК-ийн арилжааны банканд байршуулсан 52.0 тэрбум төгрөг байна.

Урт хугацаат үнэт цаас өмнөх оноос 636.1 тэрбум төгрөгөөр өссөн нь Монголын төмөр зам ТӨХК нь Тавантолгой төмөр зам ХХК-д оруулсан хөрөнгө оруулалт 463.2 тэрбум, Төрийн банк ХХК 142.2 тэрбум төгрөгөөр үнэт цаас худалдан авснаас шалтгаалжээ.

Урт хугацаат зээл өмнөх оноос 439.9 тэрбум төгрөгөөр өсөхөд ОУВС-д оруулсан хувь оролцооны үлдэгдэл ханшийн өөрчлөлтөөр 76.1 тэрбум, Эрдэнэс Оюу Толгой ХХК нь Оюу толгой ХХК-иас нэмж гаргасан 385.6 тэрбум төгрөгийн 38.5 сая ширхэг хувьцааг, Монгол-Японы хамтарсан Нью УБ интернэйшнл эйрпорт ХХК-ийн энгийн хувьцааны 13.1 тэрбум төгрөгийн 49.0 хувийг эзэмшсэн нь нөлөөлжээ.

Найм. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл цэвэр дүнгээр 37,653.0 тэрбум, эцсийн үлдэгдэл 45,820.9 тэрбум болж, 8,167.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт №23. Үндсэн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Газар	33,357.0	277,258.5	243,901.5	3.0
Биет хөрөнгө	20,971,129.2	22,889,985.2	1,918,856.0	23.5
Биет бус хөрөнгө	15,388,675.6	17,959,651.0	2,570,975.4	31.5
Бусад хөрөнгө	1,259,837.7	4,694,001.2	3,434,163.5	42.0
Дүн	37,652,999.5	45,820,895.9	8,167,896.4	100.0
<i>Үүнээс байгууллагын төрлөөр</i>				
ТӨҮГ болон ОНӨҮГ	22,656,941.7	30,480,942.8	7,824,001.1	60.2
Төсөвт байгууллага	14,460,886.9	14,867,580.4	406,693.5	38.4
Төсөл/сан	535,170.9	472,372.7	-62,798.2	1.4
Дүн	37,652,999.5	45,820,895.9	8,167,896.4	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өсөлтийн 92.6 хувь буюу 7,178.9 тэрбум төгрөг нь УУХҮЯ-ны үндсэн хөрөнгөтэй холбоотой байна. Тухайлбал:

- Тавантолгой төмөр зам ХХК-ийн бусад эргэлтийн бус хөрөнгөнд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын дуусаагүй ажил 864.4 тэрбум төгрөг;
- Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөхөөр Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн эзэмшилд буй Салхитын мөнгө, алтны ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, түүнээс олсон орлогоос төрд ногдох өгөөжийг барьцаалсан үнэт цаас гаргах зорилгоор үүсгэсэн 1,146.7 тэрбум төгрөгийн хойшлогдсон хөрөнгө;
- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын газар эзэмших, ашиглах эрхийг үнэлсэн 2,474.0 тэрбум төгрөг.

Аудитын илрүүлэлт:

- Худалдан авах ажиллагааны тухай хууль тогтоомжийг зөрчиж нийт 14.6 тэрбум төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн /ЭМЯ 6.5 тэрбум, БОАЖЯ 4.5 тэрбум, ХХААХҮЯ 2.1 тэрбум, ЭХЯ 1.2 тэрбум, Хэнтий 0.1 тэрбум, СЗХ 0.1 тэрбум, Дархан 0.1 тэрбум/.
- Үндсэн хөрөнгийн дансны ангилал буруу бүртгэсэн, үр ашиггүй зарцуулсан, зардалд тусгасан, тогтоол шийдвэргүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу зэрэг бүртгэл тайлагналтай холбоотой 270.9 тэрбум төгрөг /ЭМЯ 135.0 тэрбум, ЗТХЯ 17.8 тэрбум, Соёлын яам 16.0 тэрбум, ЭХЯ 15.0 тэрбум, УУХҮЯ 11.6 тэрбум, ХХААХҮЯ 3.4 тэрбум, БШҮЯ 3.0 тэрбум, ХЗДХЯ 0.8 тэрбум, ХНХЯ 0.8 тэрбум, БОАЖЯ 0.4 тэрбум, ЗГХЭГ 0.4 тэрбум, Өвөрхангай 23.7 тэрбум, Архангай 10.5 тэрбум, Дархан 10.2 тэрбум, Хөвсгөл 7.6 тэрбум, Нийслэл 6.4 тэрбум, Сүхбаатар 3.8 тэрбум, Баян-Өлгий 2.1 тэрбум, Хэнтий 2.0 тэрбум, Говьсүмбэр 0.4 тэрбум/.

Дуусаагүй барилга, байгууламж

Дуусаагүй барилга, байгууламж дансны эхний үлдэгдэл 1,064.5 тэрбум, эцсийн үлдэгдэл 1,222.7 тэрбум болж, 158.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Дууссан барилга байгууламжийг хүлээн авах улсын комиссын акт гараагүй, ашиглагч байгууллагад шилжүүлээгүйгээс ашиглалтад орсон хөрөнгөд элэгдэл тооцогдохгүй, тайлант үеийн зардал дутуу илэрхийлэгдэж байна.

Аудитын илрүүлэлт:

Барилга байгууламжийг хүлээж авах улсын комиссын акт гараагүй, ашиглагч байгууллагад шилжүүлээгүй 39.8 тэрбум төгрөгийн хөрөнгө байна. Үүнд:

- Захиргаа, ачаа, шуудан тээврийн үйлчилгээ, нисэх буудлын үйлчилгээний барилга 6.7 тэрбум, Эгийн голын УЦС барих 3.8 тэрбум, Булган аймгийн дулааны станцын шугамын шинэчлэл 0.8 тэрбум, Алтан дорнод монгол ХХК-ийн татварын ерөнд хураалгасан сургалтын төвийн барилга 3.4 тэрбум, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Хөгжлийн төвийн барилгын монголын тал хариуцах гадна зураг төсөл 1.9 тэрбум, МУИС-ийн Хөгжлийн сан ТББ-ын үл хөдлөх хөрөнгө 0.2 тэрбум, Амгалан амаржих газрын барилга 0.5 тэрбум, ОУ-ын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл 22.0 тэрбум, Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төсөл 0.5 тэрбум төгрөг.

Гүйцэтгэгч компанитай маргаантай, санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдээгүй 19.9 тэрбум төгрөгийн дуусаагүй барилга байна. Үүнд:

- ГХЯ-ны Ёслол хүндэтгэлийн өргөөний барилга 5.2 тэрбум, ХААИС-ийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр 0.3 тэрбум, номын сангийн өргөтгөлийн барилга 1.2 тэрбум, Олон улсын хэл судлалын төвийн барилга 0.4 тэрбум, ШУТИС-ийн оюутны 2,3 дугаар байр, лабораторийн барилгын 0.4 тэрбум, Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийн агуулах 1.4 тэрбум, Яармаг орон сууцны хорооллын цахилгаан хангамжийн барилга 8.5 тэрбум, яармагийн гүүр орчмын орон сууцны хорооллын дэд станц 1.0 тэрбум, Ирээдүй цогцолбор хорооллын 2 дугаар ээлжийн бохир усны барилга 0.1 тэрбум, Улаанбаатар хотын хаалттай хуваарилах байгууламж 7-ийн өргөтгөлийн 1.4 тэрбум төгрөг.

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланд санхүүжилт нь зогссон, эх үүсвэр батлагдаагүй, гүйцэтгэгч ажлаа дуусгаагүй, улсын комисс хүлээж аваагүй 55.8 тэрбум төгрөгийн дуусаагүй барилга байна. Тухайлбал:

- Дархан-Уул 10.6 тэрбум, Дорноговь 8.9 тэрбум, Хөвсгөл 7.6 тэрбум, Сэлэнгэ 4.9 тэрбум, Сүхбаатар 4.6 тэрбум, Архангай 4.5 тэрбум, Өмнөговь 4.3 тэрбум, Дундговь 2.2 тэрбум, Дорнод 1.6 тэрбум, Баян-өлгий 1.3 тэрбум, Баянхонгор 1.6 тэрбум, Нийслэл 1.5 тэрбум, Төв 1.2 тэрбум, Увс 0.7 тэрбум, Булган 0.2 тэрбум, Говьсүмбэр 0.1 тэрбум/

Ес. ӨР ТӨЛБӨР

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 33,178.7 тэрбум, эцсийн үлдэгдэл 42,659.8 тэрбум болж, 9,481.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №24. Нийт өр, төлбөр дансны ангилал, байгууллагын төрлөөр /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн (+), Буурсан (-)	Дүнд эзлэх хувь
<i>Богино хугацаат өр төлбөр дүн</i>	3,521,882.4	5,203,111.5	1,681,229.1	12.2
Богино хугацаат үнэт цаас	15,575.3	228,045.1	212,469.8	0.5
Богино хугацаат зээлийн өглөг	1,441,547.7	1,605,983.3	164,435.6	3.8
Өглөг	1,591,091.0	2,280,976.6	689,885.6	5.3
Урьдчилж орсон орлого	473,668.4	1,088,106.5	614,438.1	2.6
<i>Урт хугацаат өр төлбөр дүн</i>	29,656,813.6	37,456,704.0	7,799,890.4	87.8
Урт хугацаат үнэт цаас	12,695,201.0	14,634,581.3	1,939,380.3	34.3
Урт хугацаат зээл	16,961,612.6	22,822,122.7	5,860,510.1	53.5
Дүн	33,178,696.0	42,659,815.5	9,481,119.5	100.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр:</i>				
Төрийн сан	23,227,009.2	27,372,464.7	4,145,455.5	64.2
ТӨҮГ болон ОНӨҮГ	9,314,463.3	14,510,898.8	5,196,435.5	34.0
Төсөвт байгууллага	368,351.6	354,434.5	-13,917.1	0.8
Төсөл/сан	268,871.9	422,017.5	153,145.6	1.0
Дүн	33,178,696.0	42,659,815.5	9,481,119.5	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өр төлбөрийн өсөлтөд төрийн өмчит хуулийн этгээд 3,839.9 тэрбум, төрийн сан 3,868.6 тэрбум, төсөл сан 82.9 тэрбум, төсөвт байгууллага 8.5 тэрбум төгрөгөөр урт хугацаат өр төлбөр нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Богино хугацаат өр төлбөр өмнөх оноос 1,681.2 тэрбум төгрөгөөр, урт хугацаат өр төлбөр 7,799.9 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь дараах өр төлбөрийн өсөлттэй холбоотой байна. Тухайлбал:

- Санхүүгийн нэгтгэсэн тайланд шинээр нэгтгэгдсэн 14 ТӨҮГ-ын богино хугацаат өр төлбөр 16.5 тэрбум;
- Төв төрийн сангийн урт хугацаат гадаад бонд, зээлийн өр ханшийн өөрчлөлтөөр 1,351.4 тэрбум, гадаад зээлийн ашиглалтаар 3,088.8 тэрбум;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн өр төлбөр 5,196.4 тэрбум төгрөг.

Гадаад эх үүсвэрээс бага хүүтэй, урт хугацаатай зээл ашиглаж, хүүгийн зардал хэмнэж байгаа боловч сүүлийн 3 жилд гадаад бонд, зээлийн ханшийн зөрүүнээс нийт 3,478.2 тэрбум төгрөгийн алдагдал хүлээсэн нь өрийн дарамтад орох үр дагавартай байна.

Үнэт цаас, зээлийн өглөг

Нийт өр төлбөрийн 92.1 хувь буюу 39,290.7 тэрбум төгрөгийг үнэт цаас, зээлийн өглөг эзэлж байна.

Хүснэгт №25. Үнэт цаас, зээлийн өглөг /сая төгрөг/

Үнэт цаасны зориулалт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төв төрийн сангийн өр төлбөр дүн	22,981,556.6	26,850,113.1	3,868,556.5	68.3
Дотоод бонд	1,414,745.7	1,151,741.1	-263,004.6	2.9
Гадаад үнэт цаас, бондын өглөг	21,566,810.9	25,698,372.0	4,131,561.1	65.4
Гадаад бондын өглөг	7,945,315.7	8,355,180.9	409,865.2	21.3
Үнэт цаас	820,646.1	1,129,380.5	308,734.4	2.9
Гадаад зээл /хөнгөлөлттэй/	12,800,849.1	16,213,810.6	3,412,961.5	41.2
ТӨҮГ болон ОНӨҮГ-ын дүн	7,997,987.7	12,201,184.9	4,203,197.2	31.1
Дотоод бонд	482,000.0	1,007,579.0	525,579.0	2.6
Гадаад үнэт цаас, бондын өглөг	7,515,987.7	11,193,605.9	3,677,618.2	28.5
Гадаад бондын өглөг	2,048,068.8	3,147,502.4	1,099,433.6	8.0
Үнэт цаас	0.0	71,242.5	71,242.5	0.2
Гадаад зээл	1,122,558.8	1,104,549.2	-18,009.6	2.8
Зээлийн өглөг	4,345,360.1	6,870,311.8	2,524,951.7	17.5
Бусад байгууллагын зээлийн өглөг	134,392.2	239,434.5	105,042.3	0.6
Гадаад зээл	113,660.2	196,156.5	82,496.3	0.5
Зээлийн өглөг	20,732.0	43,278.0	22,546.0	0.1
Дүн	31,113,936.5	39,290,732.5	8,176,796.0	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үнэт цаас, зээлийн өглөгийн өсөлт нь Төв төрийн сангийн 3,868.6 тэрбум, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн 4,203.2 тэрбум төгрөг байна. Үнэт цаас, зээлийн өглөгийн 68.3 хувь буюу 26,850.1 тэрбум төгрөгийг Төв төрийн сангийн өр төлбөр эзэлж байна.

Төв төрийн сангийн үнэт цаас, зээл

Хүснэгт №26. Төв төрийн сангийн бонд, гадаад зээлийн өглөг /сая төгрөг/

Үзүүлэлт	Дотоод бонд	Гадаад бонд	Гадаад зээл	Дүн
Нэмэгдсэн дүн		2,048,958.0	4,104,072.4	6,153,030.4
Бонд		1,712,748.0		1,712,748.0
Зээлийн ашиглалт			3,088,829.2	3,088,829.2
Ханшийн алдагдал		336,210.0	1,015,243.2	1,351,453.2
Хасагдсан дүн	263,004.6	1,622,120.8	691,111.0	2,576,236.4
Үндсэн төлбөр	263,004.6	1,622,120.8	691,111.0	2,576,236.4
Хүүгийн төлбөр	157,067.5	577,830.3	197,922.2	932,820.0

Эх сурвалж: Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төв төрийн сангийн үнэт цаас, зээл 6,153.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн, 2,576.2 тэрбум төгрөгөөр хасагдсан байна. Тухайлбал:

- Тайлант онд олон улсын зах зээлд 1,712.7 тэрбум төгрөгийн “Номад” бондыг арилжаалж, “Мазаалай” бондын 1,048.9 тэрбум, “Чингис-1” бондын 573.2 тэрбум, нийт 1,622.1 тэрбум төгрөгийн төлбөрийг төлсөн;
- Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд зориулан авсан гадаадын зээлийн ашиглалт 3,088.8 тэрбум, ханшийн алдагдал 1,015.2 тэрбум, нийт 4,104.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн;
- Улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан дотоод үнэт цаасны үндсэн төлбөрт 220.0 тэрбум, хүний хөгжил сангийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан дотоод үнэт цаасны үндсэн төлбөрт 43.0 тэрбум, гадаад зээлийн үндсэн төлбөрт 691.1 тэрбум төгрөгийг төлсөн байна.

Дотоод бондын 157.1 тэрбум, гадаад бондын 577.8 тэрбум, гадаад зээлийн 197.9 тэрбум, нийт 932.8 тэрбум төгрөгийн хүү төлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Гадаад зээлийн эх үүсвэрээс санхүүжсэн 297.8 тэрбум төгрөгийн төсөлд эрсдэлийн үнэлгээ хийгээгүй, нийгэмд бий болох ач холбогдлоор нь эрэмбэлээгүй;
- Урт хугацаат дотоод бондын хөнгөлөлт 15.5 тэрбум төгрөгийг богино хугацаат өр төлбөрийн ангилалд, гаалийн түр горимын өглөг 18.4 тэрбум төгрөгийг бусад өглөгийн дансанд бүртгэсэн;
- ЗТХЯ, БХБЯ-ны санхүүгийн нэгтгэсэн тайланд гадаад зээлийн эх үүсвэрээс дамжуулан зээлдүүлсэн 321.7 тэрбум төгрөгийн зээлийг бүртгэх, Засгийн газрын 2006 оны 185 дугаар тогтоолоор баталсан "Гадаадын зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам"-ыг Өрийн удирдлагын тухай хууль болон Өрийн удирдлагын стратегийн баримт бичигтэй уялдуулан шинэчлэн баталж, мөрдөх талаар өгсөн өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд

Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн өр төлбөрийн эхний үлдэгдэл 9,314.5 тэрбум, эцсийн үлдэгдэл 14,510.9 тэрбум төгрөг болж, 5,196.4 тэрбум төгрөгөөр өссөн.

Хүснэгт №27. Төрийн өмчит хуулийн этгээдийн өр төлбөр /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн (+), Буурсан (-)	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	2,757,346.6	4,113,838.8	1,356,492.2	28.2
Богино хугацаат үнэт цаас	0.0	212,469.8	212,469.8	1.4
Богино хугацаат зээлийн өглөг	1,440,871.0	1,591,655.0	150,784.0	10.9
Өглөг	1,018,598.1	1,658,746.6	640,148.5	11.4
Урьдчилж орсон орлого	297,877.5	650,967.4	353,089.9	4.5
Урт хугацаат өр төлбөр дүн	6,557,116.7	10,397,060.0	3,839,943.3	71.8
Урт хугацаат үнэт цаас	2,530,068.8	4,013,854.0	1,483,785.2	27.8
Урт хугацаат зээл	4,027,047.9	6,383,206.0	2,356,158.1	44.0
Дүн	9,314,463.3	14,510,898.8	5,196,435.5	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өр төлбөрийн 4,226.3 тэрбум төгрөг нь үнэт цаас, 7,974.8 тэрбум төгрөг нь зээлийн өглөг, 2,309.7 тэрбум төгрөг нь бусад өглөг байна.

Тайлант хугацаанд Эрдэнэс Монгол ХХК 212.5 тэрбум төгрөгийн богино хугацаат үнэт цаас шинээр арилжаалсан байна.

Урт хугацаат үнэт цаас өмнөх оноос 1,483.7 тэрбум төгрөгөөр өссөн нь Эрдэнэс Монгол ХХК 736.5 тэрбум, Төрийн банк ХХК 71.2 тэрбум, Монгол Улсын Хөгжлийн банк ХХК 150.1 тэрбум,

Монголын төмөр зам 525.9 тэрбум төгрөгийн урт хугацаат үнэт цаас нэмэгдсэнтэй холбоотой байна.

Урт хугацаат зээл өмнөх оноос 2,356.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. Тухайлбал:Эрдэнэс Силвер Ресурс ХХК 936.0 тэрбум, Эрдэнэс Тавантолгой ХК 882.3 тэрбум, Нийслэлийн орон сууцны корпораци 258.0 тэрбум, МИАТ ТӨХК 149.9 тэрбум, Төрийн банк ХХК 114.5 тэрбум төгрөг байна.

Аудитын илрүүлэлт:

- Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой 146 хуулийн этгээд мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй боловч 181.6 тэрбум төгрөгийн татвар, НДШ-ийн өглөгийг барагдуулаагүй;
- Тайлант онд шинээр үүссэн зээл нэмэгдсэнээс шалтгаалж зээлийн хүүгийн өглөг 87.5 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 25.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Төсөвт байгууллагын өр төлбөр

Төсөвт байгууллагын өр төлбөрийн эхний үлдэгдэл 368.3 тэрбум, эцсийн үлдэгдэл 354.4 тэрбум болж, 13.9 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №28. Төсвийн байгууллагын нийт өр, төлбөр /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн (+), Буурсан (-)	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	347,981.1	325,556.4	-22,424.7	91.9
Богино хугацаат зээлийн өглөг	57.3	1,859.0	1,801.7	0.5
Өглөг	280,684.2	248,353.9	-32,330.3	70.1
Урьдчилж орсон орлого	67,239.6	75,343.5	8,103.9	21.3
Урт хугацаат өр төлбөр дүн	20,370.5	28,878.1	8,507.6	8.1
Үүнээс, УТЕЗ	296,692.2	265,471.9	-31,220.3	74.9
ОНТЕЗ	71,659.4	88,962.6	17,303.2	25.1
Дүн	368,351.6	354,434.5	-13,917.1	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өр төлбөрийн 74.9 хувийг улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын, 25.1 хувийг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын үлдэгдэл эзэлж байна.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 325.5 тэрбум /ХЗДХЯ 60.5 тэрбум, ЗТХЯ 31.3 тэрбум, ХНХЯ 29.5 тэрбум, ЭМЯ 22.9 тэрбум, БХБЯ 20.2 тэрбум, Өмнөговь 21.2 тэрбум, Нийслэл 17.8 тэрбум, бусад ТЕЗ 122.1 тэрбум төгрөг/, урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 28.9 тэрбум төгрөг /ХНХЯ 5.2 тэрбум, ЗГХЭГ 2.5 тэрбум, ХХААХҮС 1.4 тэрбум, Нийслэл 19.3 тэрбум, бусад ТЕЗ 0.5 тэрбум төгрөг/ байна.

Нийгмийн даатгал, Эрүүл мэндийн даатгалын сангийн өр төлбөр

Нийгмийн даатгалын сангийн өр төлбөр дансны эхний үлдэгдэл 21.0 тэрбум, эцсийн үлдэгдэл 27.0 тэрбум төгрөг болж, 6.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн өр төлбөр дансны эхний үлдэгдэл 2.7 тэрбум, эцсийн үлдэгдэл 2.6 тэрбум төгрөг болж 0.1 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн эцсийн үлдэгдэлд төр хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн санхүүжилттэй холбоотой ХНХЯ-нд өгөх 2.5 тэрбум, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, бусад зардлын 0.1 тэрбум төгрөгийн өглөг байна.

Арав. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 34,021.8 тэрбум, эцсийн үлдэгдэл 35,887.5 тэрбум болж, 1,870.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №30. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал	7,645,981.1	8,407,367.3	761,386.2	23.4
Өмч	14,659,401.7	15,063,953.6	404,551.9	42.0
Нэмж төлөгдсөн капитал	43,222.8	7,412.0	-35,810.8	0.0
Эздийн өмчийн бусад хэсэг	5,214,618.8	7,823,617.4	2,608,998.6	21.8
Хуримтлагдсан үр дүн	-658,022.3	-3,473,456.3	-2,815,434.0	9.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,111,898.6	7,881,593.5	769,694.9	22.0
Засгийн газрын хувь оролцооны дүн	34,017,100.7	35,887,540.4	1,870,439.7	100.0
Хяналтын бус хувь оролцоо	4,676.2	4,676.2	0.0	0.0
Дүн	34,021,776.9	35,892,216.5	1,870,439.7	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Цэвэр хөрөнгө / өмчийн өөрчлөлтийн тайланд төрийн өмчийн 5, орон нутгийн өмчийн 3 хуулийн этгээдийн 4.7 тэрбум төгрөгийн цөөнхийн хувь оролцоог тусдаа толилуулсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1,870.4 тэрбум төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Засгийн газрын оруулсан капитал данс, өмч, эздийн өмчийн бусад хэсэг дансны өсөлтөд улс орон нутгийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн эх үүсвэрээр бэлтгэсэн хөрөнгө, Засгийн газрын 2020 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай” 10 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд газар эзэмших, ашиглах эрхийг шинээр үнэлж бүртгэсэн зэрэг нь голлон нөлөөлсөн байна. Тухайлбал:
Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж бүртгэсэн 2,474.0 тэрбум, Оюу толгой ХХК-ийн гаргасан хувьцааны Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн эзэмшлийн 34 хувьд ногдох өөрчлөлт 385.6 тэрбум, Тавантолгой төмөр зам ХХК-ийн хувьцаа эзэмшигчдээс нэмж оруулсан хөрөнгийн дүнгээр 472.9 тэрбум, Тавантолгой төмөр зам ХХК-ийн 187.0 сая ширхэг 467.5 тэрбум төгрөгийн энгийн хувьцааг эргэлтэд оруулж, хувьцаа эзэмшигчдийн гэрээнд заасан хувиар хувьцаанд хөрвүүлсэн өмч байна.
- Хуримтлагдсан үр дүн 2,815.4 тэрбум төгрөгөөр буурахад 45 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн зарласан 1,287.0 тэрбум төгрөгийн ногдол ашгийн өглөг, 199.2 тэрбум төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга, тайлант үеийн үр дүн 1,329.2 тэрбум төгрөгийн сөрөг дүнтэй илэрхийлэгдсэн нь тус тус нөлөөлжээ.
- Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 769.7 тэрбум төгрөгөөр өсөхөд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ 647.5 тэрбум, Багануур ХК 60.7 тэрбум, Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК 48.6 тэрбум, бусад байгууллагуудын хөрөнгийн дахин үнэлгээний хэлбэлзлээр 12.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн харьяа 16 байгууллагын дахин үнэлгээний зөрүү дансны үлдэгдэл дэлгэрэнгүй бүртгэлээс 3.4 тэрбум төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн;
- Нийслэлийн ТЕЗ-ийн харьяа Нийслэлийн орон сууцны корпораци ХК-ийн үнэт цаас гаргах тогтоол шийдвэрт үнэт цаасны тоо, төрөл, гаргах хугацаа, нөхцөлийг заагаагүй, Орон нутгийн өмчийн 6 хуулийн этгээдийн санхүүгийн тайланд тусгагдсан өмчийн дүн нь улсын бүртгэлийн гэрчилгээний дүнгээс зөрүүтэй бүртгэгдсэн, Нийтийн аж ахуйн үйлчилгээний төвийн зориулалтаар ашиглах 608 мкв газар эзэмших эрхийн гэрчилгээтэй газрыг үнэлж санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Арван нэг. АСУУДЛЫГ ОНЦЛОХ ХЭСЭГ БА БУСАД АСУУДЛЫН ХЭСЭГ

Тайлант онд Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахал болон эдийн засаг, нийгмийн чиглэлээр дараах онцлох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд

- Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2020 оны 09 дүгээр тогтоолоор компанийн нэгж хувьцаанд 90 төгрөгийн ногдол ашиг олгохоор тооцон 2,512,768 хувьцаа эзэмшигч иргэдэд 179.8 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэж, тайлант онд 2,014,362 иргэнд 144.3 тэрбум төгрөгийн ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан олгожээ.
- Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийн дагуу Эрдэнэс Монгол ХХК өөрийн охин компани болох Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн эзэмшилд буй Салхитын мөнгө, алтны ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, түүнээс олсон орлогоос төрд ногдох өгөөжийг барьцаалан үнэт цаас гаргах замаар иргэдийн тэтгэврийн зээлийн тодорхой хэсгийг төлөхөөр шийдвэрлэжээ.
Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газрын 2020 оны 50, 191 дүгээр тогтоолын дагуу тэтгэвэр барьцаалсан зээл аваагүй иргэдэд 1.0 сая төгрөгтэй тэнцэх үнэт цаас эзэмшүүлэх, 1.0 сая төгрөгөөс бага тэтгэвэр барьцаалсан зээлийн үлдэгдэл төлбөртэй иргэнд зөрүү төлбөрийн дүнтэй тэнцүү хэмжээний үнэт цаас эзэмшүүлэх, 6.0 сая буюу түүнээс доош үнийн дүнтэй зээлийг төрөөс бүрэн барагдуулахад зориулан 894.7 тэрбум төгрөгийн хямдруулсан, нийт 1,146.7 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнийн дүн бүхий 5 жилийн хугацаатай 21,410,667,549 ширхэг үнэт цаасыг гаргасан байна.
- Засгийн газрын 2020 оны “Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” 211 дүгээр тогтоолын дагуу айл өрх болон зарим аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур, цэвэр бохир ус энгийн хог хаягдлын төлбөрийг төрөөс хариуцаж, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ийн 2019 оны цэвэр ашгаас 2020 оны 12 дугаар сард ногдох 66.9 тэрбум төгрөгийг төлөхөөр тооцоо гарсан байна.

Арван хоёр. АУДИТЫН ГОЛ АСУУДАЛ

1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт хөрөнгийн 28.9 хувийг эргэлтийн хөрөнгө эзэлж, өмнөх оноос 1,684.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. Тайлант онд нийт өр төлбөр 9,481.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 42,659.8 тэрбум төгрөг болсон ба өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүнгийн 54.3 хувьтай тэнцэж байна.
2. ХХААХҮС, БОАЖС, ХНХС, МУДШ, ЭМС, МУШС, ҮАБЗ, ЭМДС, ЗТХС, УУХҮС, ЭХС, Соёлын сайд, ХЭҮК, Нийслэл, Өмнөговь, Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Хязгаарлалттай санал дүгнэлт өгсөн байна.

Арван гурав. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ДҮН

Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайлангийн аудит

Улсын төсвийн 32 ерөнхийлөн захирагч, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангийн тайланд аудит хийж Зөрчилгүй 21, Хязгаарлалттай 13 дүгнэлт өгсөн байна.

Хүснэгт № 31. Хязгаарлалттай дүгнэлт авсан төсвийн ерөнхийлөн захирагч

Д/д	Хязгаарлалттай дүгнэлт:
1	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
2	Зам, тээврийн хөгжлийн сайд
3	Монгол Улсын Шадар Сайд
4	Соёлын сайд
5	Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч
6	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
7	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга
8	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
9	Хүний эрхийн үндэсний комиссын дарга
10	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
11	Эрүүл мэндийн даатгалын сан

12	Эрүүл мэндийн сайд
13	Эрчим хүчний сайд

Аудитад 1,643 төсөв захирагч, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төсөл хөтөлбөрийн нэгжийн тайлан хамрагдахаас 1201 байгууллагад дүгнэлт гаргаж /Зөрчилгүй 1,069, Хязгаарлалттай 119, Сөрөг 10, Санал дүгнэлт гаргахаас татгалзсан 3/, 85 байгууллагад итгэл үзүүлж, 349 байгууллагыг аудитын түүвэрт хамруулж, 8 байгууллага аудитад хамрагдаагүй байна.

Аудитаар нийт 3,607.7 тэрбум төгрөгийн 5,318 алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 2,283.5 тэрбум төгрөгийн 1,095 алдааг залруулж, 17.7 тэрбум төгрөгийн 440 алдаа, зөрчилд төлбөрийн акт тогтоож, алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 924.1 тэрбум төгрөгийн 1,260 зөрчилд албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 382.4 тэрбум төгрөгийн 2,523 зөвлөмж хүргүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайлангийн аудит

Орон нутгийн 22 төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар Зөрчилгүй 19, Хязгаарлалттай 3 /Нийслэл, Өмнөговь, Сэлэнгэ/ дүгнэлт өгсөн байна.

Аудитад 4,859 төсөв захирагч, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төсөл хөтөлбөрийн нэгжийн тайлан хамрагдахаас 2720 байгууллагад дүгнэлт гаргаж /Зөрчилгүй 2,315, Хязгаарлалттай 369, Сөрөг 27, Санал дүгнэлт гаргахаас татгалзсан 9/, 388 байгууллагад итгэл үзүүлж, 1,751 байгууллагыг аудитын түүвэрт хамрагдсан байна.

Аудитаар нийт 877.0 тэрбум төгрөгийн 12,989 алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 474.1 тэрбум төгрөгийн 2,962 алдааг залруулж, 4.7 тэрбум төгрөгийн 1,367 зөрчилд төлбөрийн акт тогтоож, алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 217.0 тэрбум төгрөгийн 3,037 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 181.2 тэрбум төгрөгийн 5,623 зөвлөмж хүргүүлсэн байна.

Төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн аудит

Төрийн өмчит 161 хуулийн этгээдээс Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаалаар 1 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлж, 157 байгууллага аудитад хамрагдаж, үйл ажиллагаа явуулаагүй 3 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийгдээгүй байна.

Аудитад хамрагдсан 157 хуулийн этгээдээс 12 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 145 байгууллагын санхүүгийн тайланд бие даасан санал дүгнэлт өгсөн. Үүнээс: Зөрчилгүй 127, Хязгаарлалттай 17, 1 байгууллагад дүгнэлт өгөхөөс татгалзсан байна.

Аудитаар нийт 1,063.7 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 856.8 тэрбум төгрөгийн алдааг залруулж, 1.6 тэрбум төгрөгийн зөрчилд 53 акт тогтоож, 145.3 тэрбум төгрөгийн зөрчилд 237 албан шаардлага, 60.0 тэрбум төгрөгийн зөрчилд 448 зөвлөмж өгөв.

Хүснэгт.№32 Өөрчлөлттэй дүгнэлттэй байгууллагууд

Дүгнэлтийн хэлбэр	Байгууллагын нэр
Хязгаарлалттай	Монгол Ус ТӨААТҮГ
	Төрийн орон сууцны корпораци ТӨҮГ
	Бөртэ ТӨҮГ
	Автотээврийн үндэсний төв ТӨҮГ
	Булган АЗЗА ТӨХК
	Иргэний нисэхийн ерөнхий газар ТӨҮГ
	Монголын төмөр зам ТӨХК
	Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор
	Буянт ухаа спортын ордон ТӨҮГ
	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ
	Даланзадгадын ДЦС ТӨХК
	Диспетчерийн үндэсний төв ТӨҮГ
	Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК

	Дулаан шарын гол ТӨХК
	Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК
	Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК
	Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨХК
Дүгнэлт өгөхөөс татгалзсан	Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв

Засгийн газрын гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн санхүүгийн тайлангийн аудит

Гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй нийт 133 /Сангийн ямаар дамжин хэрэгжих 107, ТЕЗ-д хамаарах 26/ төсөл хөтөлбөрөөс Хараат бус аудитын хуулийн этгээд 62 санхүүгийн тайланд гэрээгээр аудит хийж “Зөрчилгүй” 57, “Хязгаарлалттай” 5 дүгнэлт өгч /Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, Бүс нутгийн авто зам хөгжүүлэх засвар арчлалтын төсөл, Зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулах замаар эдийн засгийг төрөлжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл, Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл, Эрчим хүчний төсөл II/, аудитын түүвэрт 58 төсөл хамрагдаж, ашиглалт гараагүй 11, хэрэгжиж дууссан 2 төсөлд аудит хийгээгүй байна.Үүнд:

Хүснэгт № 33. Аудитад хамрагдаагүй төслүүд

Ашиглалт гараагүй:	Хэрэгжиж дууссан төсөл:
Архивын ерөнхий газрын цогцолбор барилгын тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт төсөл	Гал түймэртэй тэмцэх техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх төсөл
Биокомбинат үйлдвэрийн өргөтгөл	Гамшиг ослын үед үүрэг гүйцэтгэх хээрийн эмнэлэг төсөл
Дэд бүтэц хөгжил /Баянзүрх-Дархан-Сэлэнгэ төсөл/	
Улаанбаатарын төвийн дулаан хангамжийн төсөл /Европын сэргээн босголт хөгжлийн банк/	
Хөдөөгийн суурь боловсролын чанарыг ахиулахад мэдээллийн технологийг оновчтой ашиглах төсөл	
Хүнсний ногооны үйлдвэрлэл, нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх	
Яармагийн шинэ гүүр барих, хуучин гүүрийг засварлах төсөл	
Японы буцалтгүй тусламжаар Ерөнхий боловсролын сургууль байгуулах төсөл	
Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих төсөл	
Аймгийн бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл	
Туул гол дээгүүрх Баянзүрхийн 321 у/м болон Сонсголонгийн 289.4 у/м төмөр бетон гүүрийг шинээр барих төсөл	

Аудитаар нийт 463.9 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 304.5 тэрбум төгрөгийн алдааг залруулж, 0.1 тэрбум төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоож, 156.9 тэрбум төгрөгийн 59 албан шаардлага, 2.4 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 64 зөвлөмж хүргүүлээ.

Засгийн газрын тусгай сангуудын санхүүгийн тайлангийн аудит

Засгийн газрын 23 тусгай сангаас 14 тусгай санд Төрийн аудитын байгууллага, 1 тусгай санд хараат бус аудитын хуулийн этгээд, 8 тусгай сан аудитын түүвэрт хамрагдсанаас 9 санд Зөрчилгүй, Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Шинжлэх ухаан, технологийн сан, Эрүүл мэндийн даатгалын сангуудад Хязгаарлалттай, Хөдөө аж ахуйг дэмжих санд Дүгнэлт өгөхөөс татгалзсан байна.

Аудитаар нийт 492.1 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 13.3 тэрбум төгрөгийн алдааг залруулж, 296.4 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 42 албан шаардлага хүргүүлж, 182.4 тэрбум төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 30 зөвлөмж өгсөн байна.

Арван дөрөв. САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ, ЗАЛРУУЛГА

Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад дараах залруулгыг хийлгэлээ.Үүнд:

- Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд төв төрийн сангийн 25.5 тэрбум, төгрөгийн авлага, өглөгийн үлдэгдэл, үр дүнгийн тайланд 213.8 тэрбум төгрөгийн давхардсан орлого, зардлын гүйлгээ болон нийгмийн даатгалын сангийн 436.5 тэрбум төгрөгийн авлага, өглөгийн давхардсан гүйлгээг залруулав.

Арван тав. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулахаар Монгол Улсын Ерөнхий сайдад 3, Сангийн сайдад 4 зөвлөмж өгснөөс хэрэгжилтийг хянаж, үнэлэхэд 63.4 хувийн биелэлттэй байна. Үүнд:

- Монгол Улсын Ерөнхий сайдад өгсөн 2 зөвлөмж хэрэгжих шатандаа, үндсэн хөрөнгийн хөдлөлийн бүртгэлийг цахимжуулах арга хэмжээ авах зөвлөмж хэрэгжээгүй;
- Сангийн сайдад өгсөн 4 зөвлөмж хэрэгжих шатандаа байна.

Арван зургаа. ДОТООД АУДИТ

Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар нь төсвийн ерөнхийлөн захирагчдын дотоод аудитын нэгжийг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангах, дотоод аудит, санхүүгийн шалгалт хийх, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, эрсдэлийн удирдлагаар хангах, чанарын баталгаажуулалт хийх, сургалт зохион байгуулах, хэрэглэгчийг зөвлөгөө, мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Аймаг, нийслэл болон улсын ТЕЗ-дын дэргэдэх дотоод аудит, хяналт шалгалтын алба тайлант онд нийт 944 байгууллагад санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийж, нийт 30.3 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж, 24.3 тэрбум төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, 6.0 тэрбум төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосноос 3.2 тэрбум төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж, 0.2 тэрбум төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Арван долоо. ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг баталгаажуулах аудитыг Аудитын олон улсын стандарт, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2-т заасны дагуу гүйцэтгэсэн.

Аудитын явцад хийсэн горим, сорилын үр дүнд санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдтэй зөрчилдсөн материаллаг хэмжээний алдаа, зөрчилтэй дараах асуудлууд илэрсэн нь Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1705, Аудитын Олон улсын стандарт 705, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-д заасны дагуу Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дараах үндэслэлээр “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн болно. Үүнд:

1. “Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай” хууль, дагалдах журамд сангийн эх үүсвэрийг нөхөн бүрдүүлэх талаар тодорхой тусгаагүй, чөлөөлөлтөөс үүссэн 642.6 тэрбум төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
2. Дамжуулан зээлийн 321.7 тэрбум төгрөгийг ашиглагч байгууллагууд санхүүгийн тайланд өр төлбөрөөр бүртгэж тайлагнаагүй;
3. Төрийн өмчит хуулийн этгээдийн ирээдүйд бий болох орлогоос төрд ногдох өгөөжийг барьцаалан 1,146.7 тэрбум төгрөгийн урт хугацаат үнэт цаас гарган, өр үүсгэж, иргэдийн тэтгэвэр барьцаалсан зээлийг төрөөс төлсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.7-д “төрөөс хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, хөтөлбөр, арга хэмжээ, татвар ногдуулалт, эсхүл хөнгөлөлт, баталгаа, зээл, өр төлбөр, санхүүгийн үйл ажиллагаа, болзошгүй өр төлбөр, тэдгээрийн үр дүн нь өнөө болон ирээдүй үеийн хооронд тэгш бус байдал үүсгэхгүй байх” гэж заасантай тус тус нийцээгүй;

4. Эдийн засаг, нийгмийн ач холбогдлоор нь эрэмбэлээгүй, эрсдэлийн үнэлгээ хийгээгүй 297.8 тэрбум төгрөгийн 12 төслийг гадаад зээлийн эх үүсвэрээс санхүүжүүлж, урт хугацаат өр төлбөрийг нэмэгдүүлсэн байна.

Арван найм. ДҮГНЭЛТ

1. Олон улсын зах зээлд “Номад” бондыг 1,712.7 тэрбум төгрөгөөр арилжаалж “Мазаалай” бондын 1,048.9 тэрбум, “Чингис-1” бондын 573.2 тэрбум, нийт 1,622.1 тэрбум төгрөгийн төлбөрийг хугацаанаас өмнө төлсөн нь нийт 17.5 тэрбум төгрөгийн хүүгийн зардлыг хэмнэсэн байна.
2. Төрийн байгууллагуудын арилжааны банк дахь мөнгөн хөрөнгийн удирдлага, эрх зүйн зохицуулалт хангалтгүйгээс зарим банканд байршиж буй хөрөнгөд эрсдэл үүссэн хэвээр байна.
3. Төсвөөс санхүүжүүлэхээр шийдвэртэй гэр хорооллын өрхийн цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлтийн 7.3 тэрбум, төр төлбөрийг нь хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 26.5 тэрбум төгрөгийн авлагын үлдэгдэл байна.
4. Сум хөгжүүлэх сангийн 59.5 тэрбум, Орон нутгийн хөгжлийн сангийн 3.3 тэрбум төгрөгийн иргэд, аж ахуйн нэгжээс авах хугацаа хэтэрсэн, тооцоо нийлж баталгаажуулаагүй авлагын үлдэгдэлтэй байгаа нь сангуудын хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд тавих хяналт сул, санхүүгийн сахилга бат хангалтгүй байна.
5. Дуусаагүй барилга, байгууламж дансанд улсын болон орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын 3-аас дээш жилийн насжилттай 152.6 тэрбум төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.
6. Засгийн газрын гадаад бондын үлдэгдэл 8,355.2 тэрбум, гадаад зээлийн үлдэгдэл 16,213.8 тэрбум төгрөгт хүрсэн байна.
7. Тайлант онд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд зориулан 3,088.8 тэрбум төгрөгийн гадаадын зээлийн ашиглалт гарсан нь нийт өр төлбөрийг 32.6 хувиар өсөхөд нөлөөлжээ.
8. Төрийн өмчит хуулийн этгээдийн өр төлбөр өмнөх оноос 1.5 дахин буюу 5,196.4 тэрбум төгрөгөөр өссөн, үүний дотор төрийн өмчит 4 хуулийн этгээдийн үнэт цаас 4,226.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Арван ес. АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

УЛСЫН ИХ ХУРАЛД ТОЛИЛУУЛАХ НЬ:

1. Гамшгийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх хууль эрх зүйн орчныг сайжруулах;
2. Нийгмийн даатгалын шимтгэлийн чөлөөлөлтөөс үүссэн эх үүсвэрийг нөхөн бүрдүүлэх эрх зүйн зохицуулалтыг хангах;
3. Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангаарх авлагын үлдэгдэл 5,486.4 тэрбум төгрөгийг барагдуулж, хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх талаар Засгийн газарт чиглэл өгч, хэрэгжилтийг хангуулж ажиллахыг уламжилж байна.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД-д:

1. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль болон Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичигт нийцүүлсэн өрийн зохицуулалтын үйл ажиллагааг авч хэрэгжүүлэн макро эдийн засаг, төсөв, санхүүд дарамт учруулахгүйгээр өрийг төлж барагдуулах арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх;

2. Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн бүртгэлийг цахимжуулах, нэгдсэн санг бий болгох, хуульд заасны дагуу эд хөрөнгийн улсын үзлэг тооллогыг зохион байгуулах төсөв хөрөнгийг шийдвэрлэх;
3. Төрийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн өр төлбөрийг барагдуулах, алдагдлыг бууруулах зэрэг үйл ажиллагааны үр дүнг удирдлагын ажлын гүйцэтгэлтэй уялдуулж дүгнэх;
4. Орон нутгийн хөгжлийн сан болон Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг үр ашиг, үр нөлөөтэй зарцуулалж, түүнд тавих хяналтыг сайжруулах, арга хэмжээ авч ажиллах;
5. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 63.4 хувийн биелэлттэй байгаа тул аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг бүрэн хангуулж ажиллах.

САНГИЙН САЙД-д:

1. Арилжааны банканд төрийн байгууллага данс нээх, түүнийг хаахтай холбогдсон журмыг шинэчлэн боловсруулах, дансдын мэдээллийг цахимаар авч, мөнгөн хөрөнгийн удирдлага, бүртгэл хөтлөлтийг сайжруулах;
2. Дамжуулан зээлийн 321.7 тэрбум төгрөгийг ашиглагч байгууллага болох ЗТХЯ, БХБЯ-ны санхүүгийн тайланд өр төлбөрөөр тусгуулж, тооцоо нийлж баталгаажуулан, гэрээний дагуу эргэн төлөлтийг хангуулах;
3. Дампуурсан банк болон Хадгаламж зээлийн хоршооноос авах 481.1 тэрбум, Төв төрийн сангийн 1991-1996 онд хувийн хэвшлийн 89 байгууллагад олгосон 232.4 тэрбум, нийт 713.5 тэрбум төгрөгийн найдваргүй, эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн авлагыг шийдвэрлэх;
4. Гадаадын зээл, тусламжийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн үр ашигтай төсөлд зарцуулж, үр өгөөжийг дээшлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийгээгүй төсөл, хөтөлбөрийг шинээр төлөвлөхгүй байх;
5. Ашиглалтад орсон барилга, байгууламж, хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлэх, санхүүгийн тайланд тусгуулах, хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.